

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-33

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг сонсох 4-33

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Ёс зүй, дэгийн байнгын хорооны 11 дүгээр сарын 06-ны
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны
товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 53.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 09 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: А.Ариунзаяа, Ж.Батсуурь, Д.Жаргалсайхан, Ч.Лодойсамбуу;
Тасалсан: Б.Жавхлан.

Нэг. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн Л.Цэдэвсүрэн, Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны гишүүн Д.Баатарсайхан, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Пүрэвдагва, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга Б.Солонгоо, мөн газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын дарга, Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга П.Сарангэрэл, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Өнөрбаяр, Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Б.Доржсэмбэд, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга Б.Солонгоо, Байнгын хорооны 10 дугаар тогтоолын хүрээнд Боловсролын яамнаас хэрэгжүүлсэн ажлын явцын талаарх

мэдээллийг Боловсролын сайд П.Наранбаяр, Байнгын хорооны 10 дугаар тогтоолын 1.4, 1.5 дахь заалтын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн Л.Цэдэвсүрэн нар танилцуулав.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар үг хэлэв.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Б.Хэрлэн, Д.Бум-Очир, Г.Очирбат, Д.Энхтуяа, Д.Рэгдэл нарын тавьсан асуултад Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга Б.Солонгоо, Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн Л.Цэдэвсүрэн, Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар Байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолтой холбогдуулан боловсруулсан “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Баярбаатар: “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хорооны бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг хангах, эрх зүйн орчныг сайжруулах, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 2
Бүгд: 8
75.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, Д.Бум-Очир нарын саналыг “дэмжсэн”-ээр тооцож, 100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хорооны бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг хангах, эрх зүйн орчныг сайжруулах, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Д.Рэгдэл, Д.Бум-Очир, Б.Хэрлэн, Д.Энхтуяа нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 48 минут үргэлжилж, 13 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим,
15 цаг 09 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баярбаатар: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн Ёс зүй, дэгийн байнгын хорооны хуралдаан ирц хүрсэн учраас хуралдааныг нээснийг мэдэгдье.

Баярмагнайн Баярбаатар ирсэн. Аюушийн Ариунзаяа чөлөөтэй. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн ирсэн. Жамбын Батсуурь гишүүн чөлөөтэй. Дуламын Бум-Очир гишүүн ирсэн. Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн. Болдын Жавхлан гишүүн ирээгүй байна. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн чөлөөтэй. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн чөлөөтэй. Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна. Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна. Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна. Доржзодовын Энхтуяа гишүүн ирсэн байна.

Ингээд ирц хүрсэн. 4 гишүүн гадаадад томилолттой явна.

Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулна.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга харууцлагын байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх мэдээлэл сонсох.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орно.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцуулъя.

Наранбаяр Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд, Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн, Амартөгс Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Баатарсайхан Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны гишүүн, Идэрчулуун Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны гишүүн, Солонгоо Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга, Сарангэрэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын дарга, Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга, Өнөрбаяр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мягмар ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Ганхуяг БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ням-Очир Боловсролын ерөнхий газрын дарга, Доржсэмбэд Сангийн яамны Санхүү, хяналт эрсдэлийн удирдлагын газрын дарга гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Мэдээлэл танилцуулна.

Эхлээд 1 дүгээрт, Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Засгийн газрын

дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга Солонгоо танилцуулна.

2-т, Байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолын хүрээнд Боловсролын яамнаас хэрэгжүүлсэн ажлын явцын мэдээллийг Боловсролын сайд Наранбаяр танилцуулна.

3-д, Байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолын 1.4, 1.5 дахь заалтын хэрэгжилтийн мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн Цэдэвсүрэн танилцуулна гэсэн ийм 3 танилцуулга явах нь ээ.

Ингээд дарааллын дагуу Солонгоо дарга танилцуулгаа эхэлье. Хэддүгээр микрофон вэ? 4. 4 дүгээр микрофоныг өгөөрэй.

Б.Солонгоо: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаар товч мэдээлэл өгье.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан. Мөн Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичиг болон бусад бодлогын баримт бичгүүдэд чадварлаг ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх асуудал туссан байгаа.

Тэгээд үндсэн бодлогын баримт бичгүүдийн мэдээллийг танилцуулж байна. Цаашид хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шаардлагатай арга хэмжээг аваад хэрэгжүүлээд ажиллаж байна.

Төрийн албаны ёс зүйн тухай хууль батлагдсанаас хойш өнгөрсөн хугацаанд бид нарын хувьд байгуулах шаардлагатай дэд хороог байгуулсан. Нөгөө талаараа шаардлагатай танин мэдэхүйн болон соён гэгээрүүлэх ажлуудыг хийж хэрэгжүүлсэн.

Дараагийн слайдыг явчих уу.

Хамтарсан Засгийн газар байгуулагдсанаас хойших хугацаанд хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг шинэчлэн баталсан. Тэгэхээр хуульд нийцүүлээд өмнө нь мөрдлөг болгож байсан ёс зүйн хэм хэмжээний журмыг 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан.

Тэгээд энэ шинээр батлагдсан ёс зүйн хэм хэмжээг төрийн албан хаагчдад сурталчлан таниулах шаардлагатай арга хэмжээг авахаар төлөвлөөд ажиллаж байна.

Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 74 дэх Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан. Энэхүү Ёс зүйн дэд хороог миний бие ахалж байгаа. Тэгээд холбогдох байгууллагуудын төлөөлөл ороод ажиллаж байна.

Ёс зүйн дэд хороо хуралдаанаа хийж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, журмаа баталсан. Тэгээд энэхүү төлөвлөгөөний дагуу дараагийн ажлууд хийгдээд явна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд Ёс зүйн дэд хороо 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Тэгээд энэ Ёс зүйн дэд хороо маань яг ЗГХЭГ болон харьяа байгууллагуудтай холбоотой мэдээллүүдийг авч ажиллаж байна. Бидний хувьд цаашидаа үйл ажиллагаагаа зохион байгуулахдаа юуны өмнө төрийн албан хаагчдад мэдээлэл, зөвлөмж хүргүүлэхэд анхаарлаа хандуулаад ажиллаж байна.

Тэгээд энэ хүрээнд сургалт, семинаруудыг зохион байгуулах ялангуяа Удирдлагын академитай хамтран сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулаад ажиллаж байна. Төсвийн

иууд захирагч нарт Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах чиглэлийг хүргүүлсэн. Төрийн зарим байгууллагууд төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээний талаар сургалт зохион байгуулж байна.

Зөвхөн бид нарын хувьд энэ соён гэгээрүүлэх арга хэмжээг орон нутаг даяар зохион байгуулахын тулд удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авахдаа танхимын болон цахим сургалтыг хамтад нь зохион байгуулж байгаа. Цахимаар мэдээж сургалтын агуулга байх нь шинээр ажилд орж байгаа төрийн албан хаагчид болон орон нутагт хүрч ажиллахад томоохон дэмжлэг болж байгаа.

Тэгээд нийт сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын мэдээллийг слайдаар хүргүүлж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн 1 дүгээр түвшний сургалтад нийт 13981 төрийн албан хаагч хамрагдсан байна. 2 дугаар түвшний сургалтад 11584, 3 дугаар түвшний сургалтад 11265 төрийн албан хаагчид тус тус хамрагдсан байна.

Дараагийн слайд. Бид нарын хувьд Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны хувьд хуулиар хүлээлгэсэн чиг үүрэг өргөн хүрээтэй байгаа. Тэгээд гомдол, мэдээлэл шалгаж шийдвэрлэх хүрээний хувьд сум, дүүргийн Засаг дарга, баг, хорооны Засаг дарга, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, Засгийн газраас томилдог бусад албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан, төсвөөс санхүүжилт авдаг ТББ-ын удирдах албан тушаалтан гээд маш өргөн хүрээтэй шалгах шийдвэрлэх цар хүрээтэй.

Одоогийн байдлаар 1 гомдол ирсэн. Тэгээд гомдлын агуулга бол харилцаа хандлага, захирах захирагдах ёс зөрчсөн, төсвийн үр дүнгүй

зарцуулалттай холбоотой 1 гомдол ирсэн. Энэ гомдлыг шалгаж байна.

Цаашидаа бидний хувьд Ёс зүйн дэд хорооны талаар, үйл ажиллагааны талаар илүү их мэдээллийг сурталчлан таниулснаар ирэх өргөдөл, гомдлын тоо нэмэгдэх хүлээлттэй байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороон дээр ирсэн гомдол, мэдээллийг аваад үзэх юм бол 2 гомдол ирсэн байна. Тэгээд энэ 2 гомдлын аль аль нь харилцаа хандлагын зөрчил. Тэгээд үүн дотроо төрийн улс төрийн албан хаагчтай холбоотой гомдол ирсэн байна.

Ёс зүйн дэд хороон дээр гомдол ирэхээс гадна хамгийн чухал бид нарын хувьд бол иргэдээс мэдээлэл авдаг гол эх сурвалж Иргэд олон нийттэй харилцах 11 11 төв байгаа. Тэгээд 11 11 төв дээр ирж байгаа иргэдээс ирүүлж байгаа гомдол, мэдээллийн дийлэнх нь төрийн албатай холбоотой санал, хүсэлт байдаг. Тэгээд энэ төрийн албатай холбоотой санал хүсэлтийг дотор нь аваад үзэхээр, задлаад үзэхээр төрийн албаны хүнд суртал, ёс зүй, тэгээд харилцаа хандлагатай холбоотой гомдол яг эзэлдэг. Тэгэхдээ гомдлоос гадна талархал хүлээж авсан байна. Сүүлийн хугацаанд.

Тэгээд төрийн албаны хүнд суртал, ёс зүйтэй холбоотой гомдлыг задлаад авч үзэх юм бол 64 хувь нь яг хувь хүнтэй холбоотой буюу төрийн албан хаагчтай холбоотой гомдол байна. Тэгээд иргэдийн гомдолд өргөдөлд хариу өгөөгүй гэсэн асуудал 11 хувь, байгууллагын цахим хуудсанд байршуулсан утсаа авдаггүй гэсэн гомдол, цахим хуудасны мэдээ мэдээллийг шинэчлэхгүй байгаагаас мэдээлэл хялбар авч чадахгүй байгаатай холбоотой гомдол, төрийн бодлого, шийдвэр дүрэм журмын талаар мэдээ, мэдээлэл, тайлбар буруу гэсэн гомдол, мөн цагийн хуваарийн дагуу ажиллаагүй гэсэн гомдол ирсэн байна. Тэгээд шийдвэрлэсэн байдлыг аваад үзвэл өргөдөл, гомдлын

шийдвэрлэлтийн хувьд 58,2 хувьтай байна.

Тэгэхдээ үүн дээр нэг зүйлийг дурдах нь зүйтэй. Иргэдийн зүгээс олон удаа гомдол гаргадаг асуудал байгаа. Шийдвэрлэсэн төлөв дээр тухайн байгууллага руу шилжүүлсэн тэй холбоотой энэ шийдвэрлэсэн гэсэн юу гардаг. Тэгээд Засгийн газрын хуралдаанаар 7 хоног болгон Иргэд олон нийттэй харилцах 11 11 төв дээр ирж байгаа гомдол, мэдээллийн талаар мэдээлэл сонсдог. Үүнтэй холбогдуулж холбогдох салбаруудад анхаарах асуудал дээр тухай бүр Ерөнхий сайдаас үүрэг чиглэл өгч ажиллаж байгаа.

Цаашидаа бид нарын хувьд иргэдээс дуудлага, мэдээллийг амралтын өдрүүдээр болон ажлын бус цагаар хүлээж авах боломжийг нэмэгдүүлэх, мөн хиймэл оюун ухааныг ашиглаж иргэдэд мэдээ, мэдээллийг хурдан шуурхай хүргүүлэхтэй холбоотойгоор 11 11 төвийн энэ үйл ажиллагааг илүү сайжруулах дээр анхаарал хандуулаад ажиллаж байна. Цаашидаа энэ төрийн албан хаагчдын ёс зүйн хуулийг хэрэгжүүлэх, нөгөө талаараа нэг мөр ойлгож мөрдүүлэхтэй холбогдуулаад анхаарах шаардлагатай зүйлс гээд бид нарын хувьд энэ судалсан зүйлс байгаа.

Тэгээд ерөнхийдөө олон улсын туршилагаас аваад үзэхээр яг төрийн албаны ёс зүй гэдэг дээр юун дээр илүү их голчлон төлөвлөөд, төвлөрөөд байна вэ гэхээр авлига, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх дээр эрх мэдлээ хувийн зорилгоор ашиглахгүй байх дээр нэлээн анхаардаг юм байна. Тэгээд цаашидаа хуулийн хэрэгжилтийг ойлгомжтой тодорхой болгох, нөгөө тал талаараа Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг иргэдэд ойлгомжтой болгоход анхаарах шаардлагатай зүйлсийн хувьд БНСУ-ын төрийн албаны ёс зүйн талаар туршилага судлах нь их сонирхолтой, үр дүнтэй байж болохоор байна.

Тэгээд хууль батлагдаад багагүй хугацаа өнгөрсөн ч гэсэн нөгөө талаараа бид нарын хувьд анхаарах ёстой зүйл маань хуулийн хэрэгжилтийг ойлгомжтой болгох, иргэд энэ ёс зүйн хороодод гомдол гаргахад боломжийг нээлттэй болгох, нөгөө талаараа Ёс зүйн дэд хороод ирсэн гомдол шалган шийдвэрлэх үйл ажиллагаа дээр цаашидаа анхаарах ёстой зүйл байна гэж харж байгаа. Тэгээд энэ олон улсын туршилага, чиг хандлагыг цаашидаа судлахаас гадна хууль, эрх зүйн орчныг илүү тодорхой ойлгомжтой болгох асуудлууд байна гэдгийг манай ЗГХЭГ дээр тодорхой зүйлсийг судалж байна.

Дараагийн слайд дээр энэ анхаарах асуудалтай холбоотой мэдээлэл байна. Тэгээд энэ ерөнхийдөө гомдол, мэдээлэл шалгах, шийдвэрлэх хүрээг бас илүү оновчтой болгох шаардлагатай болов уу гэж харж байна. Тэгээд Засгийн газрын дэргэдэх дэд хорооны хувьд бид нар цаашидаа ажлын ачаалал нэмэгдэхээр харагдаж байгаа.

Нөгөө талаараа орон нутгаас гомдол ирлээ гэхэд орон нутагт томилолтоор ажиллах, тухайн ирсэн гомдлыг ямар хүрээнд шалгаж шийдвэрлэх вэ гэдэг дээр одоогийн байдлаар ажлын зохион байгуулалтын хувьд анхаарч ажиллаж байна.

Тэгээд ёс зүй, ёс суртахуун, ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, ёс зүйн шаардлага, ёс зүйн хэм хэмжээ зэрэг тодорхойлолт, ойлголтын зөрөөг арилгах шаардлагатай байна гэж үзэж байна.

Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоог сайжруулах, ёс зүйн хууль тогтоомжид шинжилгээ хийх замаар төрийн албан хаагчийн ёс суртахууныг зохицуулсан давхардал, хийдэл, зөрчлийг цэгцлэн, ёс зүйг нэгдмэл байдлаар авч үзэх шаардлагатай.

Нөгөө талаараа хариуцлага шийтгэлээс илүүтэйгээр эерэг хандлага, зан үйлсийг дэмжсэн урамшууллын механизмыг авч үзэх нь зүйтэй байна гэж харж байна.

Тэгээд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр цаашид төрийн байгууллагуудад бүх шатад, мөн орон нутагт ч гэсэн төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний талаар мэдээлэл өгөх сургалт зохион байгуулах. Тэгээд энэ сургалтыг давтамжтайгаар, үе шаттайгаар хэд хэдэн сургалтын агуулгаар зохион байгуулах нь үр дүнтэй харагдаж байгаа. Тэгээд мэдээж цахим сургалтын хөтөлбөр цаашид бид нарын хувьд боловсруулж, нийт төрийн албан хаагчдадаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон энэ ёс зүйн хэм хэмжээний журмын талаар мэдээлэл өгч ажиллана.

Тэгээд төрийн албан хаагчдад зориулсан ёс зүй, хариуцлагын гарын авлага гаргаж түгээх, төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлагын асуудлаар контент, шторк хийж нийгмийн сүлжээнд байршуулах зэрэг асуудал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна гэж үзэж байна.

Тэгээд ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны процессыг илүү хялбарчлах, цахимжуулах, гомдол мэдээлэл шалгаж шийдвэрлэхэд зарцуулж байгаа хугацааг багасгах болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг бид нар холбогдох бусад байгууллагуудтай ялангуяа Төрийн албаны зөвлөлтэй болон Ёс зүйн хороотойгоо хамтарч зохион байгуулах боломжтой гэж харж байгаа.

Тэгээд ерөнхийдөө нийт үйл ажиллагаа явуулж байгаа дэд хорооны талаар мэдээлэл аваад үзэхээр 1127 дэд хороо үйл ажиллагаа явж байна. Үүнээс 308 гомдол, мэдээлэл ирээд байгаа юм байна. Тэгээд цаашид нэмэлт

шаардлагатай мэдээллийг бид нар тухай бүр өгөөд явах болно. Тэгэхдээ энэ хууль батлагдаад төдийлөн урт хугацаа өнгөрөөгүй, нөгөө талаараа 2024 он Улсын Их Хурлын ээлжит сонгууль байсан нь онцлог ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Болчихсон уу, Солонгоо дарга. Баярлалаа.

Солонгоо дарга ажил аваад удаагүй байгаа, тийм ээ, тийм. Одоо бид нар энэ ёс суртахууны, нийгмийн ёс суртахууны төлөвшлийг энэ төрийн албан хаагчдаараа дамжуулж түүчээлэх зайлшгүй шаардлагатай. Энэ бол бид нар гол зорилго гэж харж байгаа.

Таны саяын ярьсан зүйлүүд их чухал чухал асуудлуудыг хөндлөө. Бид нар зөвхөн хурал зөвлөгөөний хэмжээнд ингэж хамтарч ажиллахгүй ээ. Цаашид бид нар ер нь нэлээн ойр ажиллах ёстой. Шаардлага байгаа. Өнөөдөр бид нар энэ ёс суртахуун, ёс зүй, энэ мэргэжлийн ёс зүйн асуудлуудыг ярих цаг нь болчихсон юм. Тулгамдаж байгаа асуудал мөн үү гэвэл мөн. Одоо таны яриан дунд сая авлигын асуудал яригдаж байна. Хүнд суртлын асуудал яригдаж байна. Ашиг сонирхлын асуудал. Ерөөсөө л энэ 3 зүйл дээр энэ нийгмийн ёс суртахуун чинь уначхаад байгаа байхгүй юу.

Тэгээд үүний цаад агуулгыг нь бид нар судалж үзэх ёстой. Улс төрчдөөс болдог юм уу, эс үгүй энэ төрийн албанаасаа болдог юм уу, мэргэжил ур чадвараасаа болдог юм уу, олон зүйлүүдийг углуургаар нь судалж үзэж байж ингэж асуудалд хандана гэсэн ийм байр суурь нь гээд мэдээллийг өгч байгаа. Манай Төрийн албаны зөвлөл, Монгол Улсын Ёс зүйн хороо их идэвхтэй ажиллаж байгаа. Саяын таны дурдсан тоо 1172 чинь 2200 болчихсон байх аа, Амартөгс дарга аа, дэд хороодын тоо сүүлийн үед. Ингээд дэд хороодыг идэвхжүүлжүүлэх ёстой. Үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлтийг богино хугацаанд өгч байх ёстой.

Сургалтын агуулга маш өндөр түвшинд шинэчлэгдэж явж байх ёстой. Эргээд тэр сургалтынхаа агуулгаар бид нар хандалт тандалтыг хийдэг байх ёстой. Хамгийн гол асуудал тэр урамшууллын асуудал өөрөө их чухал шүү. Бид нар дандаа л нэг хариуцлага, болохгүй, бүтэхгүй, ингэхгүй, тэгэхгүй гэдэг зүйлийг яриад байхаас илүүтэйгээр энэ үлгэр жишээг, кэйсүүдийг бусдад нь түгээж байх ёстой байхгүй юу. Тэр байгууллагын тэр ажилтан ийм манлайллыг үзүүлж ажилласан гэдэг агуулгыг бид нар гаргаж байх ёстой. Магадгүй хэтэрхий хуучинсаг санагдаж байж магадгүй. Тэгэхдээ өнөөдөр шинжлэх ухаанд дэлхийн хэмжээнд энэ ёс зүй, ёс суртахууны асуудал нэг л онолтой шүү. Нэг л зүйлтэй байдаг. Цаг үеэ дагаж мэдээж өөрчлөгдөх зүйлүүд байлгүй л яах вэ. Сайжруулах. Тэгэхдээ дандаа дэвшилтэт хэлбэр лүү оруулаад ингээд явах ёстой гэж ойлгож байна.

Дараагийн мэдээлэл Наранбаяр сайд. 2 номерын микрофон.

П.Наранбаяр: Баярлалаа. Улсын Их Хурлын байнгын хорооны эрхэм гишүүд ээ, энд хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолын хүрээнд Боловсролын яамнаас хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн явцын товч мэдээллийг та бүхэнд хүргэе.

Тогтоолын 1.6-ийн хүрээнд:

1. төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн 10.1 дэх заалтыг хэрэгжүүлж, сургуулийн өмнөх, ерөнхий, мэргэжлийн боловсролын салбарын нийт 2152 байгууллагын Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан. Ёс зүйн дэд хороонд нийт 8544 гишүүн ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.2 дахь заалтыг хэрэгжүүлж, Боловсролын ерөнхий

газраас 7 хоног бүрийн Мягмар гарагт зохион байгуулдаг Аймаг, Нийслэлийн боловсролын газрын удирдах ажилтны цахим уулзалтаар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн танилцуулгыг хийж, 200 гаруй албан хаагчийг хамруулаад байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуультай холбоотой 20 постерыг бэлдэж, салбарын хэмжээнд цахим болон нэйж хуудсаар сурталчилсан болно.

Боловсролын ерөнхий газрын цахим сургалтын платформд Багишийн ёс зүй ба харилцаа сэдэвт модулийг байршуулан цэцэрлэг, ЕБС-ийн багш, удирдах ажилтныг бүрэн хамруулсан.

Дээд боловсролын тухай хуулийн 2.1-д нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оришино гэж хуульчлан оруулсан. Нийгэмд ёс суртахууны эерэг чиг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 23 оныг Боловсролын салбарын Ёс зүйн жил болгон зарлаж, ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн багш удирдах болон бусад ажилтнуудад ёс зүйн манлайллыг сайжруулах сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

“Сайн иргэн” аяныг АТГ, Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар, Монголын сурагчдын холбоо зэрэг байгууллагуудтай хамтран нийслэлийн ерөнхий боловсролын 50 сургуульд хэрэгжүүлж байна. Өнөөдөр яг нээлтээ хийсэн. Миний бие очиж 23 дугаар сургууль дээр нээлтэд оролцсон.

Аяны зорилго нь Монгол Улсын хүүхэд, өсвөр үеийнхэнд сайн иргэн болох, шударга ёсны талаар сургалт нөлөөллийн үйл ажиллагааг явуулж,

авлига, хүнд суртлаас урьдчилан сэргийлэх, Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах, ирээдүйн шударга иргэн төлөвшүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оришиж байна.

Салбарын хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулснаар албан хаагчид төрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэхэд тодорхой ахиц гарсан гэж үзэж байна.

Тогтоолын 1.8-ын хүрээнд:

Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын одоо хүчин төгөлдөр мөрдөж буй 1-12 дугаар ангийн 65 багц сургалтын хөтөлбөр, 33 нэр төрлийн 174 сурах бичигт 2023 онд тус тус дүн шинжилгээ хийлээ.

Сургуулийн өмнөх ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын талаар мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл, судлаачид, эцэг эх, олон нийтийн төлөөлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын холбогдох удирдах ажилтан, зөвлөхүүд зэрэг 1200 гаруй хүн танилцуулж, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.6-д заасны дагуу судалгаа болон хэлэлцүүлгийн үр дүнгээр сургуулийн өмнөх ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын мэргэжлийн зөвлөлөөр тус тус хэлэлцүүлэв.

Боловсролын ерөнхий хуулийн 23.1, 23.4-д заасны дагуу Боловсролын үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдааныг зохион байгуулж, сургуулийн өмнөх ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, үзэл баримтлалын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх боломж бүрдээд байна.

Засгийн газрын үзэл баримтлал батлах тухай 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор бид үзэл баримтлалыг батлууллаа. Уг үзэл баримтлалд Монгол хүүхдийн дүр төрх, хүүхдийг хүмүүжүүлж төлөвшүүлэх, соёл, зан заншил, үндэсний өв уламжлал, нэгдмэл үнэт зүйлс, их түүхийн агуулгыг тусгаснаар сургалтын хөтөлбөрийг шинэчлэх боломж бүрдээд байна.

Тогтоолын 1.9-ийн хүрээнд:

Бага ангийн Хүн ба нийгэм хичээлийн агуулгад хүмүүсийн харилцаа, дүрэм журам, хэм хэмжээ сахих, хувь хүний эрх, үүрэг хариуцлага, дунд ангийн Нийгэм судлал хичээлийн хичээлийн агуулгад хүний эрх, тэгш байдал, шударга ёс, иргэн эрхээ эдлэх, үүрэг хариуцлагаа биелүүлэх, эрхээ хамгаалах, зөрчил үүсэх шалтгаан, зөрчлийн эерэг, сөрөг тал, үл ойлголцол, зөрчлөөс сэргийлэх арга зам, хүний эрхийн зөрчлийг ялган таних, зөрчигдсөн эрхийг сэргээх, ахлах ангийн Нийгэм судлалын хичээлийн агуулгад иргэний эрх зүйн харилцааны тулгуур ойлголт, эрх зүйн харилцаанд оролцоход эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, эрх зүйн зөрчил, түүний бүрэлдэхүүн хууль зүйн хариуцлагын төрөл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль, шүүхийн байгууллагад өргөдөл, гомдол, нэхэмжлэл гаргах, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх, шударга, ёс, зүйтэй иргэнийг төлөвшүүлэх агуулгыг тус тус тусган хэрэгжүүлж байна.

Дээд боловсролын тухай хуулийн 20.5.2 дугаарт, дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрт шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшүүлэх, бүтээлчээр сэтгэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг заавал тусгахаар тус тус хуульчилсан.

Тогтоолын дээрх заалтуудыг хэрэгжүүлснээр дараах үр дүн бий болсон гэж үзэж байна. Үүнд:

Сургуулийн өмнөх ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын хүрээнд Боловсролын сайдын 2024 оны А6 дугаар тушаалаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах, сурах бичгийн эх зохиох ажлын хэсгийг байгуулж, өнөөдөр сурах бичгийн эхний хувилбар гараад ингээд явж байна.

2 дугаарт, ерөнхий боловсролын 1-5 дугаар ангид “иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг бүрэн тусгаж, хөтөлбөрийг шинэчлэхээр ажиллаж байна.

3 дугаарт, сургалтын хөтөлбөр болон багц хэрэглэгдэхүүнийг турших, тохирцыг шалгах ажлыг энэ хичээлийн жилд тодорхой цэцэрлэг, ЕБС-д хэрэгжүүлж байна.

4 дүгээрт, ёс суртахууны хариуцлага сургалтыг дэмжих хөтөлбөрийг Боловсролын сайдын 2024 оны А137 дугаар тушаалаар батлан ерөнхий боловсролын 10 дугаар ангид тус тус хэрэгжүүлж байна.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Б.Баярбаатар: Наранбаяр сайдад баярлалаа.

Тогтоолын энэ 23 оны 11 сарын 01-ний өдрийн энэ 10 дугаар тогтоолын дийлэнх заалт нь танай салбартай холбоотой заалтууд нэлээдгүй байгаа. Тийм ээ, Наранбаяр сайд аа. Та шинэ парламент, шинэ Засгийн газар байгуулагдаад Боловсролын сайдаар томилогдоод ингээд ажиллаад нэлээдгүй цаг хугацаа өнгөрчихсөн.

Тэгээд бид нар энэ ёс суртахууны төлөвшил гэдэг асуудал ерөөсөө энэ дунд, ахлах ангиас нь эхлээд бид нар энэ асуудлыг ярих ёстой юм байгаа юм. Өнгөрсөн хугацаанд сошиал орчинд ч тэр, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн сурах бичгийг дагасан шүүмжлэлүүд нэлээдгүй өрнөж байсныг та бүхэн мэдэж байгаа.

Дээр нь та өөрөө Япон соёлыг нэлээн мэддэг болов уу гэж би талархууштай байгаа. Дэлхийд тэргүүлж байгаа ёс суртахууны төлөвшилтэй улс шүү дээ. Тэгээд цаашилаад одоо би ингээд энэ сургуулийн нийгмийн багш нартай уулздаг юм. Өрөөндөө хүлээж аваад уулздаг юм. Нийгмийн ажилтнуудаас би хүлээж авч уулзаж байгаа. Жилд 1 удаа энэ нийгмийн ажилтан, нийгмийн багш нарыг цуглуулж, энэ Төрийн ордонд цуглуулж энэ нэг төвлөрсөн арга хэмжээ хийж байх ёстой.

Ахлах, дунд ангийн хүүхдүүд 1000 гаруй хүүхдийг энэ нийслэлийн сургуулиудаас төлөөлж, энэ төвлөрсөн арга хэмжээ хийж байх ёстой. Орон нутагт ямар арга хэмжээ хийх юм гэдэг агуулга. Ер нь цаашид бидний төлөвлөж байгаа Монгол Улс өнөөдөр, цаашидаа энэ 365 хоногийн аль 1 өдрийг энэ ёс зүйн өдөртэй болъё гэсэн тийм зорилго агуулаад явж байгаа. Энэ өдрийг бид нар энэ нийгэмд тулгамдаад байгаа асуудал, энэ ёс суртахууны доголдлын асуудал, энэ зүйлүүд бид нар хийж хэрэгжүүлсэн ажил, цаашид хийж хэрэгжүүлэх гэж байгаа ажлын талаараа нэг ярилцдаг нэг ийм өдөртэй байх ёстой. Дэлхийн ёс зүйн өдөр 10 дугаар сарын 3 дахь 7 хоногийн Лхагва гарагт байдаг юм. Тэгэхээр энэ өдөртэй нь дүйцүүлдэг юм уу ийм асуудал байна.

Дээр нь энэ Монгол Улсын Ёс зүйн хороо гэж байгаа. Энэ Ёс зүйн хороотойгоо танай салбар нэлээн ялангуяа энэ өсвөр насны хүүхдийн ёс суртахууны асуудалтай энэ сурах

бичигтэй холбоотой асуудал дээр санал солилцож, зөвлөлдөж байгаарай. Зөвхөн төрийн ажлын хүрээнд асуудал ярихаасаа илүүтэйгээр би хэлээд байгаа шүү дээ. Төрийн ажил, хурал зөвлөгөөн, ширээний ард ярихаас илүүтэйгээр хааяа нэг уулзаад нэг бичлэггүй, камергүй, нэг чөлөөт уулзалтуудыг нэг зохион байгуулдаг болооч ээ л гээд байгаа шүү дээ, би. Түүн дээр энэ болж байгаа, болохгүй байгаа зүйлүүдээ нээлттэй ярьдаг. Ер нь салбар салбар дээр нэг ийм уулзалтууд цаашидаа хийж баймаар байгаа юм.

Багш нарынхаа дунд ч тэр, нийгмийн ажилтнуудынхаа дунд ч тэр чөлөөт ярилцлагуудыг хийж, эндээс их юм гардаг юм шүү. Түүнээс бид нар нэг цаг товлоод л, тэдэн цагийн хооронд, тэдэн цагийн хооронд ийм хурал хийдэг. Микрофоны ард бүгд нэг ярьдаг, хэлдэг юмаа цэгнэдэг, танадаг. Нэг иймэрхүү бас нэг Монгол соёл байхгүй юу энэ ер нь. Үүнийг нэг тодорхой түвшинд нэг хэрэгжүүлж ажиллаарай гэж би танай салбарт, даа ялангуяа их хариуцлагатай салбар учраас би үүнийг захиж хэлэх нь зөв болов уу гэж бодож байна.

Дараагийн танилцуулга
Цэдэвсүрэн дарга. 5 номерын микрофон.

Л.Цэдэвсүрэн: Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга болон гишүүд, өнөөдрийн хуралдаанд хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 онд батлагдаж, хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр тухайн үедээ Улсын Их Хурлын 2023 оны 32 дугаар тогтоол батлагдаж, энэ тогтоолын хүрээнд тухайн үеийн Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хороо “Засгийн газарт чиглэл өгөх тухай” энэ 10 дугаар тогтоолыг баталж байсан.

Энэ тогтоолын хүрээнд манай манай Төрийн албаны зөвлөл буюу Ёс зүйн хороотой холбоотой 2 заалт байгаа. Энэ заалтын талаарх биелэлтийг гишүүддээ товч танилцуулъя.

Заалтын 1.4 нь иргэнд төрийн албанд анх ороход тавих ёс зүйн шаардлагыг өндөрсгөх, ёс зүйн зөрчил гаргаж байсан хүнийг төрийн жинхэнэ албанд буюу төрийн захиргаа, төрийн тусгай албанд томилохгүй байх, албан тушаалд дэвшүүлэхгүй байх зарчмыг хатуу мөрдөж, ажиллах ийм зохицуулалттай.

Төрийн албаны зөвлөл буюу Ёс зүйн хороо хамтраад 2023 онд батлагдсан төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмаа бид нар яг энэ хууль, Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хүрээнд шинэчлэх ажлыг эхлүүлээд явж байна. Хэд хэдэн удаагийн хэлэлцүүлгүүд зохион байгуулагдсан. Холбогдох төрийн байгууллагуудаас санал аваад явж байгаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаарх мэдлэг шалгах сорил төстийн даалгаврыг ерөнхий шалгалтын сорилын санд оруулж, энэ талын баяжилтаа хийгээд явж байна.

Тусгай шалгалтын сорилын сандаа энэ хууль болон 2024 онд батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрт заасан гол гол агуулгуудаа тусгасан ийм сорилыг бэлтгүүлэх ажлыг холбогдох их, дээд сургуулийн эрдэмтэн, мэргэд ялангуяа Удирдлагын академийнхантай хамтраад хийгээд эхлээд явж байна.

Бид энэ 10 дугаар тогтоолын хүрээнд энэ ажлыг зохион байгуулахдаа Улсын Их Хурлаас энэ онд батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх болон соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрт 2 гол зорилтыг тусгаж, үүнийгээ баталгаажуулж

чадсан. Энэ юу вэ гэхээр төрийн албан хаагчийг албан тушаалд сонгон шалгаруулж, томилоход төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдөх, төлөвшил, зан үйлийн хэв маягийг нь тодорхойлох ийм сорил, даалгаврыг бий болгох, энэтэй холбоотой ажлыг төр, хувийн хэвшил, олон нийтийн оролцоонд тулгуурлаж хийх чиглэлээр үндэсний хөтөлбөртөө тусгаж батлуулсан.

2 дахь нь, иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулах, томилох, шатлан дэвшүүлэх, шилжүүлэх, сэлгээж ажиллуулахдаа ёс зүйн энэ нийтлэг шалгуурыг хангасан эсэхийг нь эн тэргүүнд нь авч үздэг болгох, хуульд заасан шаардлагаас гадна ёс зүйн төлөвшил хариуцлага, шударга, хариуцлагатай, нийгмийн зорилгод нийцэх иргэн, албан хаагчийг сонгон шалгаруулж, төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх тогтолцоог бэхжүүлнэ гэсэн ийм зорилтуудыг энэ оны 4 сард батлагдсан үндэсний хөтөлбөртөө тусгасан.

Энэ хүрээндээ түрүүний хэлсэн сорил даалгаврын сангаа баяжуулах ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Энэ ажил маань мэдээж энэ онд тэгээд 2025 онд үргэлжилж хийгдэхээр байгаа.

Төрийн жинхэнэ албаны дэс, туслах түшмэлд хамаарах албан тушаалын сул орон тоог нөхөх шалгалтад оролцогчдыг үнэлэх нэг бүрэлдэхүүн хэсгийгээ харилцаа, хандлага, тэдний ур чадвар, бусад шалгалтад орж байгаа хүмүүсийг үнэлэхдээ тухайн албан тушаалын чиг үүрэг, онцлогтой нь уялдуулаад хандлага, ёс зүй, түүнийг хэрхэн тодорхойлоход чиглэсэн ийм асуулт даалгаврын сангуудыг тусад нь дахиад бий болгох ажлыг хийгээд явж байна. Үүнийгээ хийгээд дуусах юм бол журмыг шинэчлэх даалгаврын санг баяжуулах ажлууд

маань ингээд үр бүтээлтэй цаашаа үргэлжлээд явна.

Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо цахим систем гэж Төрийн албаны зөвлөлийн систем байдаг. Энэ систем Монгол Улсын нийт төрийн албан хаагчдын тоо бүртгэлийн нэгдсэн систем. Энэ системдээ бид нар дэд системийг бий болгоод төрийн ёс зүйн бүртгэл, хяналтын модулийг тусад нь бий болгоод энэ дээрээ сайжруулалт хийх процессын ажлыг эхлүүлсэн. Энэ системийг дэд систем болон системээ хөгжүүлэлтээ энэ оны 12 сарын 10-нд хүлээж авахаар ингээд гүйцэтгэгч байгууллагатай төлөвлөгөө гаргаад ингээд ажиллаж байгаа.

Төрийн жинхэнэ алба буюу төрийн захиргаа, төрийн тусгайгаасаа гадна төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагч гэж байгууллагын дарга нарыг энэ орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад оролцохоор ирж байгаа хүмүүсээс эрүүгийн болон иргэний хариуцлага хүлээж байсан эсэх, мөн ёс зүйн хариуцлага хүлээж байсан эсэх, 50 хувийн шаардлага хангасан төрийн захиргааны албанд өрсөлдөж байгаа хүмүүсээсээ ёс зүйн хариуцлага хүлээгээгүй байх. Энэ албан ёсны лавлагаануудыг бүгдийг нь бий болгоод, энэ лавлагааг авч сонгон шалгаруулалтыг цааш нь явуулдаг энэ ажлаа хэрэгжүүлээд явж байна.

Ер нь ёс зүйн хариуцлага, сахилгын шийтгэл хүлээж байсан төрийн жинхэнэ албан хаагч хугацаанаасаа өмнө тэр хариуцлага дуусах хугацаанаасаа өмнө ямарваа нэгэн байдлаар албан тушаал дэвших, карьер өсөх, шилжих, сэлгэх ийм боломжгүй болгохоор журмын төслөө хийгээд үүнийгээ 11 сардаа багтааж батлахаар ингээд зөвлөл болон ёс зүйн хороо ажиллаж байна.

Бид нар батлагдсан хууль, тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд шалгалт өгч байгаа

энэ болзол, журмыг ганцхан Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо хэлэлцээд байхаасаа илүүтэй олон нийтээс санал авахаар нээлттэй хэлэлцүүлэг рүү оруулаад явж байна. Энэ сарын 18-нд энэ чиглэлээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөөд, ингээд ажиллаж байгаа.

Журмыг шинэчлээд эрх зүйн зохицуулалтуудыг нь хэдий чинээ сайн хийж байгаа боловч үүнийг хэрэгжүүлэх төрийн албан хаагчдад, ялангуяа шалгалтын комиссынхон, шалгалтын бүрэлдэхүүнд орж байгаа гишүүд, нарийн бичгийн дарга нараа сургах нь хамгийн чухал асуудал байгаа. Тэгээд энэ сургалтыг үе шаттай зохион байгуулах ажлуудыг хийгээд явж байгаа.

Ёс зүйн хорооны энэ тогтоолд заасан дараагийн нэг гол ажил бид нар энэ Ёс зүйн дэд хороодыг байгуулж, дэд хороодыг мэргэжил арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, тэд нарыг үйл ажиллагаагаа хэвийн явуулахад нь дэмжлэг үзүүлэх ийм үүрэг хүлээсэн. Үүний хүрээнд Ёс зүйн дэд хороодыг байгуулах гол процесс нь юу байсан бэ гэхээр энэ дэд хорооны журмыг нь баталж өгөх хэрэгцээтэй болсон. Ёс зүйн хороо өөрөө 2024 оны 2 сард яг албан ёсоор 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхлээд бид нарын хамгийн түрүүнд хэрэгжүүлсэн ажил энэ Ёс зүйн дэд хорооны журмыг баталж, Хууль зүйн яамаар албан ёсоор улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээд, дэд хорооддоо ингээд түгээгээд ажиллаж байна. Өнөөдрийн 24 оны 10 сарын 31-ний байдлаар өнөөдөр 2016 ёс зүйн дэд хороод байгуулагдсанаас Улаанбаатар хотод 256, орон нутагт 1760 ингээд үйл ажиллагаа явуулаад эхэлчихсэн байна.

Ёс зүйн дэд хороод хэдийгээр сайн байгуулагдаад ажиллаж байгаа ч гэсэн энэ дэд хорооддоо мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тасралтгүй сургалт явуулах нь манай хорооны нэг гол ажил

болж байна. Тэгээд бид нар үүнийгээ хөдөө орон нутагт ялангуяа 3-5 сард энэ оны бүх 21 аймагтаа хүрч очиж ажиллаад, нийт нэг 13 мянга гаруй төрийн албан хаагчдыг болон Ёс зүйн дэд хороодыг хамруулсан сургалтуудыг зохион байгуулсан. Энэ мэдээж ингээд нэг удаагийн арга хэмжээ болж үлдэхгүй. Давтамжтай сургалтыг байнга хийхийн тулд манай Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 гэсэн ийм вебинар цахим сургалт байдаг. Эндээ бид нар 17 удаагийн сургалтаар нэг 5000 гаруй ёс зүйн нөгөө давхардсан тоогоор Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг хамруулсан ийм сургалтуудыг ингээд үе шаттайгаар хийгээд байна.

Сургалт соён гэгээрүүлэх ажлуудыг ингээд богино хугацаанд дэд сэдвүүдээр нь хийгээд явах нь илүү үр дүнтэй байна гэдгийг Ёс зүйн хороон дээрээ ярьсан. Яагаад гэхээр нэг удаагийн танхимын сургалт, 2 удаагийн танхимын сургалт бол магадгүй хийгээд тэр үедээ үр дүнтэй байсан ч гэсэн хэсэг хугацааны дараа мартагдах нөхцөлүүд зөндөө үүсээд байгаа учраас цахим сургалтуудыг байнгын хийх нь зөв юм байна гэж үзсэн.

Ёс зүйн дэд хороодыг чадавхжуулах, тэдний ажилд дэмжлэг үзүүлэх нэг зүйл маань гомдол, мэдээллийг хэрхэн яаж хүлээж авч, яаж шийдвэрлэх вэ гэдэг асуудал байгаа. Энэ талаар Ёс зүйн хороо хуралдаад энэ төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хэрхэн яаж хөтлөх юм, мэдээллийн сангаа яаж удирдах юм, яаж хөгжүүлэх юм гэдэг асуудлуудыг хэлэлцээд энэ чиглэлийн маягт, тайлан мэдээ, бүх зүйлүүдийг нь эхнээс нь батлаад, ингээд Ёс зүйн дэд хорооддоо хүргүүлж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн гомдол, мэдээлэл шийдвэрлэлтийг бүртгэхтэй холбоотой одоо цахим дэд системүүдээ ингээд илүү сайн ажиллуулаад, энэ дээрээ хүмүүсийг

тасралтгүй сургах ажлыг зохион байгуулаад явж байгаа.

Ёс зүйн хорооны веб сайтыг хөгжүүлээд иргэн, байгууллага, олон нийтэд хорооны үйл ажиллагаагаа хүргэх, сурталчлах, танин мэдүүлэх ажлыг тогтмол хийгээд ингээд явж байна.

Тэгэхээр Ёс зүйн хорооноос Ёс зүйн дэд хороодыг чадавхжуулах, үйл ажиллагааг нь дэмжих ажил байнгын тасралтгүй хийгдэнэ. Энэ нь 1 удаагийн, 2 удаагийн уулзалт, хурлаасаа илүүтэй аль болохоор байнгын нээлттэй мэдээллийг нь хүлээж авдаг, санал зөвлөгөөг нь хүлээж авдаг, буцаагаад хариу өгдөг ийм эргэлтийн цикл дор оруулаад ажиллаж байгаа, манай Ёс зүйн хорооноос. Тэгээд энэ ажил маань үргэлжлээд илүү сайн бүтээлчээр хийгдэнэ ээ гэдгийг эрхэм гишүүддээ хэлэх гэсэн юм.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Баярбаатар: Цэдэвээ дарга, баярлалаа. Чухал чухал мэдээллүүд өгч байна.

Саяын тэр таны хэлсэн санаан дунд манай Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо ер нь сүүлийн үед ажил нийтийн яг энэ чиглэл рүүгээ идэвхжээд явж байгаа гэдгийг манай энэ яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар, бусад энэ ажлын хэсгийн гишүүд нэг анхаарч ажиллах нь зөв болов уу гэж бодож байна. Энэ том ажлыг энд нэг Байнгын хорооны нэг хэдэн гишүүд, эс үгүй бол Төрийн албаны зөвлөл Монгол Улсын Ёс зүйн Хорооны нэг хэдэн гишүүд хийгээд ард нь гарчихдаг ажил биш шүү. Та нар энэ дээр яг үүрэг оролцоо нэгтэй оролцож ажиллах ёстой шүү. Шат шатдаа. Яаж ажиллах вэ гэдэг аргачлалаа өөрсдөө гаргаж ир. Салбар салбартаа нийцүүлээд. Тэгж байж энэ ажил урагшаагаа явна.

Тэгэхдээ бид нар энэ ажлыг хийхгүй бол тэр түрүүний яриад байгаа ашиг сонирхол, авлига, хүнд суртал гэсэн 3 зүйлээс салахгүй шүү. Хэтэрхий бид нар энэ рүүгээ хазайгаад өнөөдөр хаана илүү ашиг сонирхол байна гэдэг рүүгээ энэ төрийн алба, төрийн албан хаагчид хазайж ажиллах юм бол бид нар энэ зөв зам руугаа орох магадлал улам л нарийсна л гэж ойлгоорой.

Тэгэхээр энэ удирдлага чиглэлээр хангаж байгаа байгууллагатайгаа хамтраад асуудал юмнууддаа их хурдтай ажиллах нь зөв болов уу гэж би бодож байна.

Тэр ёс зүйн хариуцлага хүлээж байсан талаарх тэр лавлагааг тэр цахим системдээ бүрдүүлж авах нь маш зөв шүү. Үүнийг тэр дэд хороод салбар салбар дээр байгуулагдаж байгаа дэд хороод үүнийг тогтмол энэ бүртгэлжүүлэлтийг хийж байх ёстой, энэ цахим санд. Тэгээд эндээс нь Ёс зүйн хороо нь хараад энэ үйл ажиллагаагаа дүгнэж байх ёстой гэж.

Орон нутагт хүрч ажиллах, цахимаар ажиллах 2 бол чухал. Тэгээд хүрч ажиллахад манай Байнгын хороо, Байнгын хороодын гишүүдээс манай Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооныхон хамт явж болно. Ажлын хэсэгт ахлаад юм уу, ингээд очоод манай гишүүд оролцоод очоод энэ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллаж болно шүү. Энэ бол нээлттэй байгаа шүү гэдгийг хэлье.

Ингээд танилцуулга дууслаа.

Танилцуулгатай холбоотой асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Кнопоо дар. Хэрлэн гишүүнээр тасаллаа.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Хэд хэдэн асуулт байна. Энэ нөгөө Боловсролын

яамны саяын мэдээлэлтэй холбоотой нэг хэдэн асуулт байна. Энэ үзэл баримтлал 24 оны 4 сарын 176 дугаар тогтоолоор баталсан гэж байна, тийм ээ. Энэ нөгөө сурах бичиг, боловсролын хөтөлбөрийн агуулгатай холбоотой гээд. Энэ мэдээллийг бид нарт энэ Байнгын хороодын гишүүдээр 1 дүгээрт, хангаач ээ гэж хүсэх гэсэн юм.

2 дугаарт гэвэл, яг энэ нөгөө сургалтын хөтөлбөртэй холбоотой бага анги, дунд анги гээд ахлах ангийн агуулгуудыг харахаар Боловсролын ерөнхий хууль дээр жендерийн эрх тэгш байдлын тухай агуулга заавал орно гээд уг нь заалт байгаа, тийм ээ. Гэтэл яг энэ танилцуулга дээр тэр заалт ерөөсөө ороогүй байна. Тэрийг та хэд маань анхаараарай гэж хэлэх гэсэн юм.

3 дугаарт, энэ мэргэжлийн сургуулиудад Дээд боловсролын тухай хуулиудад энэ мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг заавал тусгахаар хуульчилсан гээд, тэгээд яг үүнтэй холбоотой яг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт өөрчлөлт орсон юм уу. Яг ийм сургалтын агуулгууд орсон уу гэдгийг тодруулж асуух гэсэн юм.

Өнөөдөр яг өнөөдөр Шангила дээр нийт хуульчдын ёс зүйн асуудлыг хэлэлцсэн ийм симпозиум хурал болж байна. Тэр хурал дээр энэ хуульчид бэлтгэх их, дээд сургууль дээр энэ мэргэжлийн ёс зүйн хичээлийг заавал үзэх хичээл болгох тухай л дөнгөж л ярьж эхэлж байна л даа. Гэтэл хууль нь батлагдчихаад байдаг.

Тэгэхээр энэ их, дээд сургуулиуд дээр энэ тухайн мэргэжлийн ёс зүйн сургалтын агуулга, хөтөлбөрүүд гараад энэ яа ямар хэрэгжилттэй байгаа вэ гэдгийг тодруулж асууя.

4 дүгээрт, энэ багш нарын сайн сайхан байдалтай холбоотой ямар арга хэмжээ авч байгаа вэ? Бид нар ёс зүйн шаардлага янз бүрийн юмнууд тавьж

болно. Гэхдээ багш нарынхаа нийгмийн асуудал, багш нарын сайн сайхан сэтгэл зүйн асуудал гээд энэ олон асуудлууд дээр яг энэ танай зүгээс юу хийж байгаа вэ? Ялангуяа энэ ёс зүйг хангахын тулд цаад үндсэн суурь нөхцөл нь ямар байх ёстой гэж үзэж байгаа вэ? Тэгээд үүнтэй холбоотой ямар нэгэн судалгаанууд хийгдсэн үү гэдгийг тодруулж асуух гэсэн юм.

Тэгээд хамгийн сүүлд нь боловсрол дээр энэ ёс зүйн энэ дүрэм журмыг хэрэгжүүлэхэд үүсэж байгаа ямар нэгэн хүндрэл бэрхшээл байна уу? Энэ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гэсэн үг. Тэгээд маш олон дэд хороод байгуулагдаж байна. Хоорондын уялдаа хэрхэн хангагдаж байгаа юм бол? Бүр яг төрийн үйлчилгээний албан хаагч, төрийн захиргааныхандаа хатуу үйлчилдэг ийм болчих вий дээ. Дээшээгээ удирдах албан тушаалтнууд дээр хэр энэ хуулийн үр нөлөө очиж байгаа юм бол оо? Тэгэхээр энэ хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээл ялангуяа энэ боловсролын салбарт байна уу гэдэг ийм зүйлийг боловсролынхноос асуугаадахъя.

Юунаас сая энэ Солонгоо сайдын танилцуулгатай холбоотой нэг 2 асуулт асуугаадахъя

Засгийн газрын дэргэд Ёс зүйн дэд хороо, Хэрэг эрхлэхийн дэргэд Ёс зүйн дэд хороо гээд ийм 2 дэд хороо тус тусдаа гэж ойлголоо, тийм ээ. Тэгээд нөгөө субъектүүд нь өөр ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Баасанжаргал гишүүнд нэмэлт 1 минут.

Х.Баасанжаргал: Субъектүүд нь өөр учраас ингэж ялгаатай байна уу? Дээрээс нь энэ нөгөө улс төрийн албан тушаалтантай холбоотой асуудлуудыг сайд, дэд сайд ч гэдэг юм уу тийм ээ, ер нь энэ улс төрийн албан тушаалтантай холбоотой улс төрийн томилгоогоор очдог албан тушаалтантай холбоотой

ёс зүйн асуудлыг аль дэд хороо нь шийдэж байгаа вэ? Үүний ер нь энэ шийдвэрлэлтийн явц, үүнтэй холбоотой ирдэг гомдол, мөн саад бэрхшээл янз бүрийн энэ хэрэгжилттэй холбоотой ямар нэгэн асуудал байна уу гэдгийг асуух гэсэн юм.

Б.Баярбаатар: 2 дугаар микрофон Батжаргал дарга эхлээд хариулна.

Дараа нь Солонгоо дарга хариулна.

Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал.

Таны эхний асуулт бол сая сайдын танилцуулгад дурдсанаар Боловсролын үндэсний зөвлөлөөр хэлэлцэгдээд, Засгийн газрын шийдвэр гараад, үзэл баримтлалынхаа дагуу бага болон дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажлын хэсэг ажил үргэлжлээд ид дундаа явж байгаа. Тэгээд би таны хэлсэн зөвлөмжийн дагуу боловсролын энэ хөтөлбөрийн шинэчлэлийн ажлын явц болоод дээр нь энэ үзэл баримтлалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Танд тусгайлан хүргүүлье гэж бодож байна. Мөн байнгын хорооны гишүүдэд бас гишүүний хэлсэнчлэн хүргүүлье.

Багш нарын сайн сайхан, түүнтэй холбоотой авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ гээд энэ маш чухал асуудал. Тэгээд ер нь судалгааны явцад ер нь багшийн, багш нарын ажлын байрны стресс, ажлын байр дээрх ачааллын бууруулах чиглэлээр судалгааныхаа үр дүн, дүгнэлтийн дагуу арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байгаа. Хараахан яг үр дүнг яг тодорхой хэмжээгээр тоочих дүгнэлт одоохондоо гараагүй байгаа.

Нөгөөтээгүүр энэ Багш нарын их хурал гэж болдог. Сая өнгөрсөн хавар Багш нарын их хурлаар Монгол Улсын нийт 330 сум, 21 аймагт байгаа багш

нарын төлөөллүүд ирж зовлон жаргал, тулгамдаж байгаа асуудал, багш нар дээр ирж байгаа ачаалал, ёс зүйн асуудал гарч болох гол эрсдэл бол эцэг эхээс ирж байгаа зарим нэгэн хандлага, ийм асуудал нөлөөлдөг өө гэсэн зүйлийг ч ярьж байсан.

Тэгээд нөгөөтээгүүр энэ багш нарын энэ их хурлын дүнгээр хэлэлцсэн асуудлуудыг дүгнээд багш нарын хөгжүүлэх 3 тулгуурт бодлогыг Засгийн газраар хэлэлцүүлж дэмжигдэж шийдвэр гарсан байгаа. Энэ хүрээнд багш нарын нийгмийн асуудал шийдэгдэж байна. Ачааллыг бууруулах төрөл бүрийн арга хэмжээнүүд ингээд шат дараатайгаар ингээд шийдэгдэнэ ээ гэж.

Ёс зүйн 2000 гаруй дэд хороод боловсролын салбарт ажиллаж байгаа. 8000 гаруй энэ албан хаагчид Ёс зүйн дэд хороонд ажиллаж байгаа. Энэ мэдээж тооны хувьд массын хувьд ч гэсэн тэр салбарын онцлог байгаа. Тэгэхээр бас үүнийг харилцан уялдааг хангаж, шинэ тутам батлагдан гарсан Улсын Их Хурлын тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлээд яг энэ үр дүнг нэгтгэсэн судалгаа харьцангуй богино хугацааны хэрэгжилт учраас гараагүй байна. Харин энэ чиглэлээр урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай ялангуяа Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүлийн яам, АТГ соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажил явж ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Гүйцээгээд хариулчих. 2 номерын микрофон.

Х.Батжаргал: АТГ-ын холбогдох нэгжтэй ажиллаж, илүү урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн үйл ажиллагаануудыг давамгайлж явуулж байна. Хөтөлбөрийн энэ боловсруулалт, би ярианы эхэнд хэлсэнчлэн яг ид явагдаж байна. Түүрчээсээ хамгийн эхний хувилбарууд гарах, энэ чиглэл дээр би олон нийтийн зүгээс ч гэсэн одоо,

өмнөх сурах бичгийн хөтөлбөр дээр санал, шүүмжлэл байдаг. Тэгээд тэрийг тусгаж, хүний эрхийн үндэсний хүмүүс саяын хэлсэнчлэн АТГ-ын Ёс зүй, урьдчилан сэргийлэх хэлтэс, тэгээд энэ мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг аваад энэ яг хэлэлцүүлэгт нээлттэй оролцуулаад, ингээд түрүүчээсээ хамгийн эхний хувилбарууд гараад танилцуулагдаад явж байгаа. Үүнийг холбогдох газруудаас албан ёсоор санал авч нэвтрүүлнэ ээ гэж ингэж хэлэх байна. Баярлалаа.

Б.Баярбаатар: Солонгоо дарга.

Х.Батжаргал: Их, дээд сургууль дарга аа, их ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Манай асуултад хариулж байгаа дарга нар цагаа бариад, товч тодорхой хариулна. За юу.

Солонгоо дарга.

Б.Солонгоо: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгээд яг хуулиар тодорхойлсон хүрээнд холбогдох Ёс зүйн хорооны харьяалах одоо албан тушаалтан, төрийн албан хаагчийн гомдол, мэдээ гомдлыг шийдвэрлэж байгаа.

Төрийн өндөр албан тушаалтан буюу сайд нартай холбоотой асуудлыг Монгол Улсын Ёс зүйн хороо шийдвэрлэж байна. Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны хувьд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10.2-т заасан Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн асуудлын талаар хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан. Тэгээд ерөнхийдөө Засгийн газраас томилогддог албан тушаалтнууд гэж ойлгож болно.

Тэгэхээр аймаг, нийслэлийн Засаг даргаас бусад бүх шатын Засаг даргаас гадна эрхлэх асуудлын хүрээний

холбогдох байгууллагын удирдах албан тушаалтан ... /минут дуусав/

Б.Баярбаатар: 4 номерын микрофон, сунгаад үргэлжлүүлээд хариулчих.

Б.Солонгоо: Тэгэхээр төрийн өндөр албан тушаалтнаас бусад Засгийн газрын харьяа байгууллагуудын албан хаагчдыг оруулж байгаа. Тэгээд мэдээж, бид нарын хувьд анхаарч байгаа зүйл маань цаашидаа үйл ажиллагаагаа хуульд заасан хүрээнд хэрэгжүүлэхээс гадна Засгийн газрын харьяа агентлаг, байгууллагууд дээр үйл ажиллагаа явуулж байгаа Ёс зүйн дэд хороодтой бас ажлаа уялдуулах шаардлагатай.

Хэрэг эрхлэх газрын харьяаны Ёс зүйн дэд хорооны хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын албан хаагчид болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар томилогдож байгаа албан тушаалтнууд хамаарч байгаа. Тэгэхээр нөгөө хуульд заасан чиг үүргийн дагуу энэ холбогдох дэд хороодын хамаарах хүрээг тодорхойлж байна.

Тэгээд таны асуусан улс төрийн албан тушаалтны хувьд манай тодорхой улс төрийн албан тушаалтантай холбоотой асуудал, ялангуяа төрийн өндөр албан тушаалтнуудын асуудал бол Монгол Улсын Ёс зүйн хорооны эрхлэх асуудалд хамаарч байна.

Б.Баярбаатар: Баярлалаа. Энэ дэвшилтэт зүйл л дээ. Төрийн албан хаагчдад бид нар хариуцлага тооцоод явчих ийм боломж нь хуулиар байсан бол энэ Ёс зүйн хороо байгуулагдсанаар улс төрийн албан тушаалтнуудын хариуцлагын асуудал яригдах боломж нээгдсэн ийм дэвшил гарсан гэж үзэж байгаа шүү.

Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Маш чухал асуудал яригдаж

байна. 90-ээд оноос хойш Монголд олон нийгмийн хямралын тухай асуудал яригдаж байгаа. Бид нар эдийн засгийн хямралыг л голдуу яриад байдаг. Миний ойлгож байгаагаар Монголын нийгэмд байгаа, магадгүй байсаар байгаа нэг томоохон хямрал бол би ёс зүйн хямрал гэж боддог. Нийгэм шилжихэд ёс зүй сууриараа тодорхой хэмжээгээр хөдөлдөг, өөрчлөгддөг. Бид 90 онд үндсэндээ төлөвлөсөн төлөвлөгөөт эдийн засагтай, социалист нийгмээс өнөөгийн энэ ардчилсан чөлөөт зах зээлийн нийгэмд шилжсэн. Энд бол маш том ёс зүйн шилжилт тийм үү, өөрчлөлт хийгдэж байгаа юм. Энэ өөрчлөлтөө бид даван туулж чадсан уу гэдэг асуудал байгаа.

Тэгэхээр энэ тодорхой хэмжээгээр энэ нийгэмд хямралыг авчирдаг. Энэ хямрал миний ойлгож байгаагаар тодорхой хэмжээгээр үргэлжилж байгаа. Энэ хямрал маань сүүлдээ ямар асуудал болдог вэ гэхээр Монголын нийгмийн хөгжлийн томоохон чөдөр тушаануудын нэг болдог гэж би ойлгодог юм. Судлаач ч гэсэн энэ дээр байр суурь нэгтэй байх болов уу гэж бодож байна.

Тийм учраас бид энэ ёс зүй болоод хариуцлагыг дээшлүүлэх тухай асуудлыг цаашид илүү нарийвчлан авч үзэх шаардлагатай байгаа. Бидэнд ирсэн энэ тайлан дээр бүх яамнууд болоод бүх аймгууд өнгөрсөн хугацаанд ялангуяа 23, 24 онд ямар ямар ажил хийсэн тухай тайлан мэдээлэл иржээ. Маш олон ажил хийжээ, баяр хүргэе. Сайн байна.

Миний асуух гэж байгаа асуулт энэ хийгдсэн ажлууд маань тодорхой үр дүнд хүрсэн эсэхийг яаж хэмжиж шийдэж байгаа вэ? Энэ ажлууд маань яг үр дүнтэй нь аль нь байсан юм бэ? Үр дүнгүй ажлууд ёс зүй гэдэг маш зовлонтой зүйл. Тодорхой хугацаа шаарддаг. Тэгэхээр мэдээж үүний ард маш их төсөв мөнгө байгаа. Тэгэхээр эндээсээ бид дараагийн шатанд энэ энэ

ажлууд нь илүү үр дүнтэй юм гэж барьж аваад илүү тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлэх боломж бий юү. Энэ ажлынхаа үр дүнгүүдийг яаж хэмжиж байгаа юм бэ? Ёс зүйн асуудлыг хэмжихэд маш хэцүү. Мэдээж дүрэм журамтай холбоотой асуудал байдаг хэмжих боломжтой. Гэтэл дүрэм журам дээр заагдаагүй, хуульд суудаггүй, дүрэм журамд заагддаггүй олон асуудлууд бий. Эд нарыгаа яаж хэмжиж гаргаж ирж байгаа юм бэ? 1 дүгээр зүйл.

2 дугаарт, би энэ ирсэн мэдээлэл дээрээс төрийн албан хаагчийн авлига, ашиг сонирхлын хэрэгт холбогдсон талаарх тоон мэдээллийг яг альд нь орсныг ялгаж харахгүй байгаад байна. Тийм их мэдээлэл, тийм мэдээлэл хэр их ирж байгаа юм бэ? Түүнчлэн сургуультай холбоотойгоор энэ үе тэнгийн дээрэлхэлт гэж байдаг. Тийм ээ, энэ нэмэгдэж байгаа юм уу, хасагдаж байгаа юм уу, ямаршуу байдалтай байгаа юм бэ? гэх мэтчилэн асуумаар зүйлс нэлээд байгаад байна. Ингээд ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Цэдэвсүрэн дарга хариулах уу? Амартөгс дарга. Амартөгс дарга 7 номерын микрофон.

Ц.Амартөгс: Гишүүний асуултад хариулъя. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ёс зүйн хороо байгуулагдаад 2 сараас хойш үйл ажиллагаа явуулж байгаа гэж өмнөх Цэдэвсүрэн даргын мэдээлэлд дурдагдсан. Эндээс хойших хамгийн гол нь энэ Төрийн албан хаагчийн хувь ёс зүйн тухай хууль тогтоомж гаргаснаас хойш ямар өөрчлөлт гаргах ёстой вэ гэдэг энэ бодлогын зорилтоо бид тодорхойлоод, дунд хугацааны буюу 2030 он хүртэлх баримтлах чиглэлээ үндэсний хөтөлбөрт төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан. Энэ хөтөлбөрийн тодорхой үе шатанд бид үр дүнгээ хэмжинэ гэж тооцож байгаа. Одоо бид үйл ажиллагаагаа эхлүүлээд энэ оны

зорилт юу байсан бэ гэхээр нийт энэ хуулийн хүрээнд үйлчлэлд хамаарч байгаа 4239 байгууллага, 227 орчим мянган албан тушаалтан, төрийн албан хаагч нарыг энэ хуулийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлье, ойлголт өгье, сурталчилъя. Мөн сургалт танин мэдэхүйн үйл ажиллагаа байнгын үйл ажиллагааг зохион байгуулах тогтолцоог нь бүрдүүлэхэд, бэхжүүлэхэд илүү төвлөрч ажиллала гэсэн ийм зорилгуудыг хэрэгжүүлсэн. Ингээд оны эхнээс байгуулагдсан 2016 дэд хороон дээрээ сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хийж байгаа.

Мөн байнгын шинж чанартай сургалтын тогтолцоог бүрдүүлэхийн тулд Удирдлагын академи дээр явж байгаа төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтын тогтолцоотой уялдуулах. Ингэхдээ ялгаатай байдал нь энэ албан тушаалын болон мэргэжлийн ёс зүй, ёс суртахууны хэм хэмжээний асуудал нь ялгаатай байгаа учраас сургалтын агуулга байнга ялгаатай байх юм байна гэдэг ийм үзүүлэлт байгаа.

Гарцын үр дүнг бид зохион байгуулсан болон байгуулагдсан мөн бүртгэгдсэн зөрчлийн тоогоор хяналт тавьж яг гарцаа хэмжиж байна. Илүү үр дүнд чиглэсэн гэдэг юм уу, дунд болон урт хугацаанд бол урт хугацаанд 2030 он гэхэд бид төрийн албан хаагчдад, төрийн албанд итгэх, олон нийтийн итгэлийг дээшлүүлсэн байх ёстой гэдэг ийм зорилго тавьж байгаа.

Тэгэхээр суурь түвшиндээ бид хийгдэх гэж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн төлөв байдлын судалгааны аргачлалыг боловсруулах ажлыг эхлүүлсэн. Энэ аргачлалыг боловсруулах ажил дээр тодорхой хэмжээгээр зөвлөх үйл ажиллагаа, олон нийттэй хамтарч ажиллаад шалгуур үзүүлэлт, төлөв байдлын суурь түвшнийг тодорхойлоод ахицыг нь энэ судалгаанд тавигдсан шалгуур үзүүлэлтүүдээр тоон болон чанарын хувьд нь хэмжих ийм

боломжтой болгоно гэж ингэж зорьж ажлаа эхлүүлээд энд явж байна.

Авлига, албан тушаалын хэрэгт холбогдсон талаарх мэдээлэл одоогоор яг энэ манай хуулийн үйлчлэлд байхгүй байгаа учраас бид нар гаргаж чадаагүй байгаа. Хуулийн үйлчлэлд хамаарч байгаа албан хаагчтай холбоотой мэдээлэл гэхэд 423 зөрчил бүртгэгдсэнээс 237-г нь бид дүгнэлт гаргаад, хянан шийдвэрлээд, зохих хариуцлагыг нь энэ хуулийн дагуу уучлал гуйлгах гээд ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Цэдэвсүрэн дарга нэмээд хариулчих 5 номер.

Л.Цэдэвсүрэн: Бум-Очир гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Төрийн албан хаагчийн тухай хуульд яг энэ авлига, албан тушаалтай холбоотой гэмт хэргийн асуудал байхгүй боловч Төрийн албаны хуульд нь байгаа юм. Төрийн албаны хуульд нь болохоор юу байдаг вэ гэхээр нийтийн албанд томилогдох эрх хасах ялаар шийтгүүлсэн асуудал явж байгаа. Үүнийг Төрийн албаны зөвлөл хар жагсаалт гэж бид нар тусдаа систем дээрээ юу нээгээд бүртгээд явж байна. Өнөөдрийн байдлаар буюу 2024 оны 10 сарын 31-ний байдлаар ийм ялаар шийтгүүлчихсэн 1074 төрийн албан хаагч буюу иргэн байгаа. Эндээс хамгийн их жин дарж байгаа нь эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашигласан, нийтийн албан тушаалтан хахууль авсан, хахууль өгсөн гэдэг зүйл заалтаар жишээ нь эрх мэдэл албан тушаалын байдлаар урвуулан ашигласан дээр 280 ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Үргэлжлүүлээд явах уу. 5 номер.

Л.Цэдэвсүрэн: Эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглах дээр 282, нийтийн албан тушаалтан хахууль авсан гэдэг дээр 130, хахууль өгсөн гэдэг дээр 225 тухайн үедээ төрийн алба хашиж байсан хүмүүс манай хар жагсаалтад бүртгэгдээд

ингээд явж байгаа. Ер нь 2-5 жил төрийн алба буюу нийтийн албанд ажиллах эрхийг нь шүүхээс хориглосон ийм шийдвэрүүд гардаг.

Б.Баярбаатар: 4 номер Солонгоо дарга.

Б.Солонгоо: Бум-Очир гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Тэгээд Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны хувьд бид нар үйл ажиллагааны төлөвлөгөөгөө тухай бүр боловсруулж, батлаад ажиллаж байгаа. Мэдээж Засгийн газрын хэмжээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцаж байгаа гол байгууллага бол Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага. Тэгэхээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага дээр шаардлагатай энэ хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд хийгдэнэ.

Тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд мөн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдэд тухай бүр хяналт шинжилгээ, үнэлгээ мониторинг хийгдээд явна. Тэгээд миний танилцуулгад туссан дэд хороотой холбоотой мэдээлэл бол зөвхөн яам, агентлагууд болон орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулж байгаа ЗДТГ-ын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Ёс зүйн дэд хороотой холбоотой мэдээ ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Бум-Очир гишүүн тодруулах уу? Батжаргал дарга хариулчих. 2 номер.

Х.Батжаргал: Гишүүний асуултад нэмж хариулъя. Ер нь үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой асуудлаар сүүлийн 3 жилийн хугацаанд бүр тусгайлан зорилтот аян өрнүүлээд манай Боловсролын ерөнхий газар дээр энэ хэрэгжилт хангагдаад явж байгаа. Өнгөрсөн хичээлийн жилд тухайлах юм бол 463 тохиолдол илэрч байсан бол өнгөрсөн жилийн мөн үеийнхтэй

харьцуулбал энэ хандлага, тоо хэмжээ буурч байгаа нь энэ зорилтот аяны бодит үр дүн, өгөөжөө өгч байна гэж харж байгаа юм. Мөн салбар дундын хамтын ажиллагаа энэ аяны хүрээнд, зорилтот ажлын хүрээнд нэлээн нягтарч сайжирсан байгаа. Хүүхдийн зөвлөн туслах өсвөр насны үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой энэ чиглэлээр тусгай утас сургууль болгон дээр ажиллуулж байгаа. Энэ утасны хариулт зөвлөгөөг бас үр дүнгээ өгч байгаа.

Мөн Баасанжаргал гишүүний түрүүний асуусан асуулт дээр хариулахад их, дээд сургуулиудын эрх зүйн зохицуулалт ингээд тодорхой болоод эхлэхээр бидний нөгөө тавих шаардлага нөгөө хэрэглэгчид дээр маш тодорхой болж байгаа. Тухайлах юм бол их, дээд сургуулиудын хөтөлбөр дээр нөгөө хуульчил ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Бум-Очир гишүүн тодруулъя. Нэг минут.

Д.Бум-Очир: Авлига, албан тушаалын хэрэг өөр заалтаар шийдэгдэж байгаа гэдгийг ерөнхийдөө ойлгож байна. Иймэрхүү хариулт ирэх болов уу гэж бодож байлаа.

Гэхдээ бид нар энэ хэлэлцүүлэг ярьж байгаа энэ асуудалд авлига, албан тушаалын асуудлыг оруулж ярих нь зүйтэй болов уу. Бид хүрээгээ яаж тодорхойлох юм бол, үүнийг нэг дахиж бодож үзмээр л санагдаж байна. Яагаад вэ гэхээр энэ магадгүй гэмт хэрэг зөрчил юм уу, ямар ч хуулиар шийдэгдэж байж болно. Энэ бүхний ард хамгийн ул сууринд нь ер нь ерөнхийдөө ёс зүйн асуудал байгаа шүү дээ.

Тэгэхээр бидний хамгийн түрүүнд ярих ёстой асуудлын нэг бол авлига, албан тушаалын асуудал байх болов уу гэж бодож байна. Энэ тоогоо бид цаашид бууруулах талын арга хэмжээ авах болов уу. Үүний сууринд нь миний ойлгож байгаагаар одоо ёс зүйн асуудал

байгаад байна л даа. Одоо нэг тендер зохицуулж өгөөд нэг 5, 10 хувь авдаг энэ бол Монголын нийгэмд тогтчихсон шүү дээ. Ёс бус зүйл зүгээр ёсны юм шиг болоод тогтчихсон. Энэтэйгээ бид нар яаж тэмцэх юм бэ. Энэтэйгээ тэмцмээр байгаад байна.

Б.Баярбаатар: Санал хэллээ. Хэрлэн гишүүн асуулт.

Б.Хэрлэн: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Монгол Улсын төрийн алба, Монголын төрийн албан хаагчид зөвийн үлгэр дуурайллыг Монголын нийгэмд үзүүлэх ёстой. Энэ утгаараа төрийн албаны ёс зүйн хороог бэхжүүлэх ёстой гэсэн энэ бодлого зарчимтай санал нэг байгаа. Ингээд өнөөдөр та бүхний 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил үүргийн ажлын тайлантай ингээд товч танилцаад сууж байхад 1 жилийн хугацаанд багагүй ажил хийжээ гэж ерөнхийдөө харагдаж байна. Улсын хэмжээнд 2016 Ёс зүйн хороо, дэд хороодыг байгуулсан гэсэн ийм статистик тоо байна. Өөрөөр хэлэх юм бол ер нь ёс зүйн асуудлыг өнөөдөр авч үзэхэд хууль, эрх зүйн хувьд, бүтэц зохион байгуулалтын хувьд бас нэлээн хэлбэржээд явж байгаа юм байна гэсэн ийм ойлголт ерөнхийдөө бууж байна.

Тэгээд 1 жилийн хугацаанд ер нь Ёс зүйн хороод болон дэд хороодод ирсэн өргөдөл гомдлын тоо гээд энэ дээр бид нарт нэг статистик өгсөн байна. Эндээс харахад нэг 430-аад ёс зүйн гомдол иржээ гээд. Тэгээд надад нэг асуулт байгаа нь юу вэ гэхээр мэдээж хэрэг энэ Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороод ирсэн гомдлуудад агуулгын хувьд дүн шинжилгээ хийсэн байх, тийм ээ. Ялангуяа тэр дүн шинжилгээгээ хийхдээ төрийн албаны ёс зүйн ямар зарчим өнөөдөр зөрчигдөөд байгаа юм бэ гэдэг дээр та бүхэн нэлээн нухацтай авч үзсэн болов уу гэж би бодож байна. Тухайлбал, ер нь төрийн албаны ёс зүйн зарчмууд гээд л тэгэх юм бол хамгийн энгийнээр ярих юм бол би бид нар шударга ёсны

тухай бид нар ярина. Ил тод нээлттэй байх тухай ярина. Үл ялгаварлах тухай бид нар ярина. Адил тэгш харьцах тухай бид нар ярьдаг.

Тэгэхээр энэ зарчмуудаас чухам өнөөдөр яг Монголын төрийн албанд аль нь яг зөрчигдөөд байна, энэ гомдлуудад энэ нь хэрхэн яаж туссан юм бэ гэдэг дээр дүн шинжилгээ хийсэн болов уу. Тэгээд эндээсээ үүдээд дараа дараагийнхаа өөрсдийнхөө үйл ажиллагаанд төлөвлөгөөгөө хийхдээ тийм ээ, ажлаа яг юунд чиглүүлье гэж бодож явж байгаа гэж би асуумаар байна.

Б.Баярбаатар: Амартөгс дарга 7 номерын микрофон.

Ц.Амартөгс: Гишүүний асуултад хариулъя. Ёс зүйн дэд хороод байгуулагдаад бүртгэгдсэн гомдол мэдээллийг аваад үзэх юм бол дийлэнх нь яг л нөгөө хүн хоорондын харилцаа буюу харилцаа, хандлагын асуудал дээр хууль тогтоомжид шударга үйлчлэхгүй байна гэдэг юм уу, үйлчилгээ авах нөхцөл байдал бүрдэхгүй байна гэдэг энэ агуулгаар байгаа. Энэ зарчим шударга байдлыг л илэрхийлэх ёстой.

Тийм учраас энэ хуульд байгаа бид хууль дээдлэх ёс, шударга тэгш үйлчлэх, хүний иргэний асуудалд анхааралтай хандаж, хууль тогтоомжид заасан үүргийнхээ хүрээнд бүрэн хариулах гэдэг энэ агуулгыг маш чухлаар авч үзэх ёстой юм байна гэдэг урьдчилсан тоон үзүүлэлт дээр хийж байгаа дүгнэлт ийм байна. Түрүүн бид дурдсан төрийн албан хаагчийн ер нь ёс зүйн төлөв байдал ямар байна вэ гэдэг дээр бид судалгаа хийлгэхээр аргачлал, арга зүйг тодорхойлоод явж байна.

Тэгэхээр бид энэ аргачлал арга зүйг тодорхойлоод, хэлэлцүүлээд туршилтын судалгаа хийж үзэхэд үнэхээр яг төлөв байдлыг шинж чанарыг нь илэрхийлж гаргахуйц судалгаа болох

нь уу, суурь түвшин нь ямар байна вэ гэдэг энэ нөхцөл байдал гарна гэж тодорхойлогдож байгаа. Өнөөдрийн мэдээлэлд бид нар статистик дээрээ хийсэн дүн шинжилгээг хуулийн заалт бүрээр гаргаж танилцууллаа.

Тэгээд энэ 237 зөрчил маань харилцан, 207 зөрчил маань харилцаа хандлага, 99 нь ажил үүргээ хангалттай бүрэн би хэрэгжүүлэхгүй байна гэдэгтэй холбоотой гомдол мэдээлэл байх, маш цөөхөн тооны юу нь хэмжээ нь хууль бус шаардлага тавьж байна гэдэг ийм агуулгаар ирсэн гэдэг ийм зөрчлүүд бүртгэгдсэн байгаа юм. Дэлгэрэнгүй судалгаа, төлөв байдлын тайлан дээр гарна. Өнөөдрийн тухайд тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд гаргасан мэдээлэл, түүнд байгаа статистик дээрээ дүн шинжилгээ хийж танилцуулж байна.

Б.Баярбаатар: Хэрлэн гишүүн тодруулчих.

Б.Хэрлэн: Тэгэхээр ёс зүйн ямар зарчим голдуу зөрчигдөөд байгааг тодорхой болгож гаргаж ирнэ гэдэг чинь танай байгууллагын өөрсдийн яг хийж гүйцэтгэх үйл ажиллагаанд чинь маш их хэрэг болно л доо.

Тэгэхээр ёс зүйн хороод, дэд хороод их төлөв соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулна, ёс зүйн зөрчлийг бүртгэнэ, шийдвэрлэнэ гээд тэгж байна шүү дээ, тийм ээ. Тэгэхээр соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулахын тулд ядаж сургалт явуулахад чинь ямар зарчим нь алдагдаад байгаа юм бэ? Үүнийг нь яаж амьдралд зөвөөр хэрэгжүүлэх ёстой юм бэ гэдгийгээ бид нар мэдэж байж, тэр сургалтаа явуулах юм бол хаа хаанаа сургалт явуулсан хүндээ ч тэр, сургалт авч байгаа байгууллагууддаа ч гэсэн өгөөжтэй байна байх л даа. Тэр утгаараа энэ зарчмуудын талаар сайн эргээд нөгөө гомдолдоо дүн шинжилгээ хийж хараарай гэж би хэлмээр байна.

Б.Баярбаатар: Санал хэллээ. Ер нь байгууллага байгуулагдаад үйл

ажиллагаа нь эхлээд удаагүй байгаа учраас бидэнд учир дутагдалтай зүйлүүд байгаа, Хэрлэн гишүүн ээ. Тэгэхээр энэ чанаржуулах ажилд цаашидаа яаж дэмжлэг үзүүлж ажиллах вэ, яаж анхаарах вэ гэдэг дээр бид нар бодолцох ёстой шүү.

Очирбат гишүүн.

Г.Очирбат: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгээд 2, 3 асуулт байна.

1 дүгээрт, энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуультай холбоотойгоор төрийн албан хаагч нар Төрийн албаны зөвлөлд ер нь гомдол гаргаж байсан уу гэдэг асуултыг 1 дүгээрт, асууя. Яагаад гэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн 16.16 дээр итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй гэж заасан Үндсэн хууль дээр. 2023 оны 5 сарын 4-ний өдрийн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль дээр 7.1.16 дээр төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг хүлээн зөвшөөрнө гэгчсэн байгаа. Иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг хүлээн зөвшөөрнө гэсэн байгаа шүү. Мөн хуулийн 8.2.1 дээр төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг, үйлдлээрээ эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирахгүй ээ гэгчэж байгаа.

Тэгэхээр энэ манай энэ Төрийн албаны тухай хууль маань Үндсэн хуультай зөрчилдөж байна гэж ер нь төрийн албан хаагч нар төрийн үйлчилгээний, төрийн дунд шатны, бүх шатны албан хаагч нараас гомдол гаргаж байсан тийм тоо байдаг юм уу гэдэг нэг ийм тоог сонирхож байна.

2-т гэх юм Засгийн газрын дэргэд байгуулагдсан Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаатай холбоотой Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Солонгоо дарга

материалаа түрүүлээд өгчхөж байвал их зүгээр байна. Таны өчигдрийн бид нарт шилэнгээр явуулсан материал дандаа ерөнхий. Зөвхөн бүтцийн байгууллагуудаасаа мэдээлэл татаж авчирч ирээд, нийлүүлээд бид нарт өгчихсөн байна лээ. Тэгэхээр яг тантай холбоотой мэдээллүүдийг түрүүний слайдаар гарлаа шүү дээ. Тоон мэдээллүүдийг түрүүлээд өгчхөж байвал бид нарт ингээд дахиад тэр тоон дээр чинь ажиллах ийм цаг хугацаа өгвөл их зүгээр байна гэж хэлэх гэж байна.

3-т гэх юм бол, 10 дугаар тогтоолын 3 дахь заалт буюу ёс зүйн зөрчил гаргавал өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх, холбогдох байгууллагаар шалгуулдаг байх соёлыг хэвшүүлэхэд Засгийн газар манлайлж байх утга бүхий ийм заалт байгаад байгаа. Тийм ээ. Тэгээд үүний хэрэгжилт яг ямар байгаа юм. Хэчнээн хүн яг би ингээд ёс зүйн алдаа гаргачихлаа гээд өргөдлөө өгөөд явсан ийм шийдвэрлүүлсэн асуудал байдаг юм. Яагаад гэхээр та хэдийн хийж байгаа ажлын чинь үр дүн тэгж гарах ёстой байхгүй юу? Тийм ээ.

Хамгийн сүүлийнх нь. Төрийн албаны зөвлөлтэй холбоотой асуулт л байна. Төрийн албаны зөвлөл 1 талдаа төрийн албан хаагчаа бид нар ингээд хуулиараа бүх юмаараа чангалаад байдаг. Нийт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн маань 30 хувь нь бараг төрийн албан хаагч нар байгаад байдаг. Тэгэхээр эргээгээд төрийн албан хаагчаа яаж хамгаалах гэж байгаа юм бэ. Энэ хүмүүс чинь нийгэмд тэр, улс төрч нарт ч тэр, бүр сургууль цуг төгссөн нэг үеийн төгсөгчдөд нь ч тэр, ингээд нэг ийм ад үзүүлсэн, төрийн албанд ажиллаж байгаа гэснээрээ нэг тийм нэг .../минут дуусав/

Б.Баярбаатар: 1 минут Очирбат гишүүнд өгье.

Г.Очирбат: Цаанаа нэг тийм айдастайгаар ийм хүнтэй харилцаж

байна шүү. Ялангуяа ингээд энэ сургууль, цэцэрлэгийн багш, эмч, эмнэлгийн ажилчид, төрийн жинхэнэ зарим албан хаагч нартай уулзаад суухад ерөнхийдөө бид нар ингээд бүр ингээд дарангуйллын систем рүү орчихсон шүү. Яагаад гэхээр үүнийг Үндсэн хуулийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар бүр ингээд зохицуулчихсан, мөн тэрийг дагасан салбар хоорондын журмууд байна. Түүгээр ингээд эрх, эрх чөлөөнд хэтэрхий халдаад байна. Тэгэхээр бид ингээд юм ярьж чадахгүй байна шүү гэдэг юмыг л төрийн албан хаагч нар хэлж байгаа юм.

Тэгээд энэ дээр төрийн албан хаагч нараа хамгаалах ер нь ямархуу та зүйл заалт санаачилгууд гарч байна гэдэг асуулт байна.

2-т гэх юм бол бас энэ төрийн албан хаагчтай холбоотой тэр эрүүгийн хариуцлага хүлээсэн хүнийг албан тушаал ахиулахгүй гэсэн. Бүр ингээд та энэ дүгнэлт дээрээ биччихсэн байна. Тэгэхээр энэтэй холбоотойгоор хүн юу гэдэг юм нэг 18 наснаас 30 насны хооронд залуу хүмүүс алдаж эндэж болно. Тийм биз. Энэ чинь хүний л амьдрал. Тэгэхээр үүнийг нэг хугацаатай баримжаатай болго ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Цэдэвсүрэн дарга хариулах уу? Амартөгс дарга эхлээд хариулна. Дараа нь Цэдэвсүрэн дарга 7 номерын микрофон.

Ц.Амартөгс: Гишүүний эхний асуултад хариулъя. Төрийн албан хаагчийн зарим нөгөө иргэний эрхийг хязгаарлахтай холбоотой заалт нь Төрийн албаны тухай хуульд байгаа төрийн жинхэнэ албан хаагчдад хамаарч байгаа. Ажил үүргээ гүйцэтгэхдээ нөгөө улс төрөөс ангид байх гэдэг хязгаарлалт байдаг.

Тэгэхээр тэр бол зөвхөн төрийн жинхэнэ албан хаагчдад Төрийн албаны тухай хуулиар нөгөө жагсаал цуглаанд

оролцохгүй байх тийм ээ. Улс төрийн үзэл бодлоо яг төрийн алба хаагчийн жинхэнэ албан хаагчдад зориулсан тэр хязгаарлалтыг хэлж байгаа. Тэгэхээр бусад өөр хүний эрхтэй холбоотой хязгаарлалт хориглолт байхгүй. Тэр хуулиа хэрэгжүүлэхтэй холбоотой уялдуулсан заалт.

Б.Баярбаатар: 5 номер Цэдэвсүрэн дарга.

Л.Цэдэвсүрэн: Очирбат гишүүний асуултад хариулъя. Энэ төрийн албан хаагчийн ёс зүйн чиглэлээрх, гомдол шийдвэрлэлтэй холбоотой асуудлууд дээр бид нарын нэг магадгүй Монголчуудын хувьд ч гэж хэлж болохоор нэг хэвшээгүй зүйл байдаг. Энэ нь ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээх гэж. Өмнө нь дандаа л нөгөө нэг хуулиар эсвэл шийдвэрээр хүлээдэг. Гэтэл яг өөрөө сайн дураараа ёс зүйн хариуцлага хүлээдэг. Уг нь бол 4 төрлийн хувилбар байгаа юм. Хамт олноосоо уучлалт гуйна. Эсвэл нөгөө гомдол гаргасан хүнээс өөрөөс нь уучлалт гуйдаг. Эсвэл олон нийтийн өмнө гарч уучлалт гуйдаг. Хамгийн сүүлд нь таны хэлсэн өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөх гээд. Ёс зүйн хороо болон дэд хороод байгуулагдаад хууль хэрэгжсэнээс хойш яг өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдсөн 10 хүн л байна. Ер нь яг одоогийн байгаа статистикаар. Энэ нийт нөгөө ёс зүйн хариуцлага хүлээж байгаа субъектүүдийн 4,2 хувийг ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Гүйцээгээд хариулчих. 5 номер.

Л.Цэдэвсүрэн: Хамгийн сүүлийн асуултыг нь аягүй богинохон юм чинь хурдан хариулчихъя. Түрүүн нөгөө залуу хүмүүст боломж олгох ёстой гээд. Энэ хугацаа бол ингээд насан туршидаа биш. Тэр хүн ёс зүйн хариуцлага хүлээгээд тодорхой хугацааны дараа буцаагаад төрийн албанд ажиллах эрх нь болон

цаашаагаа шатлан дэвших боломж нь нээлттэй. Түрүүний нөгөө Блэк Листийн асуудал бол магадгүй 2 жил, 4 жил, 3 жил, 5 жил нийтийн албанд албан тушаал хаших шийдвэр гарчихсан бол тэрийг дууссаны дараа тэр хүн төрийн албанд буцаагаад ажиллах боломж нь нээлттэй.

Мэдээж Төрийн албаны хуулиараа бид нар төрийн албан хаагчийгаа аль болохоор хамгаалах, дэмжих чиглэлийг тэргүүн ээлжид барьж ажиллаж байгаа. Хамгийн сүүлийн жишээг танд хэлэхэд, сая Төрийн албаны зөвлөлөөс нийт 16 яаманд хяналт шалгалт хийлээ. Гэхдээ бид нар хяналт шалгалтыг тэргүүн ээлжид тавьсангүй. Мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аль болохоор хүмүүсээ дэмжих хэлбэрийг тэргүүн ээлжид тавьж, энэ талын асуудлуудаа шийдвэрээ сая өнгөрсөн 3 дахь өдөр гаргалаа.

Б.Баярбаатар: Солонгоо дарга 4 номерын микрофон.

Б.Солонгоо: Гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн албаны шинэчлэл гээд 4.2.3 дугаар заалтад ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж, ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх асуудал туссан. Тэгээд төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршилагад суурилан хэрэгжүүлнэ ээ гээд тодорхой зорилтууд тусчихсан байгаа.

Тэгээд Засгийн газрын зүгээс үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах ажилд анхаарлаа хандуулаад ажиллаж байна.

Нөгөө талаараа бидний хувьд анхаарах ёстой зүйл маань сая Цэдэвсүрэн дарга хэлж байна. Яг хариуцлага ноогдуулах, шийдэх гэхээсээ

илүү урамиуулах, сайн ажиллаж байгаа төрийн албан хаагчдаа дэмжиж ажиллах дээр анхаарах, нөгөө талаараа санаачилгатай ажиллаж байгаа төрийн албан хаагчдаа урамиуулах дээр анхаарч ажиллах шаардлагатай байгаа.

Бидний хувьд цаашид мэдээллийг аль болох урт урьдчилж хүргүүлэх дээр анхаарч ажиллая. Засгийн газрын дэргэдэх дэд хороо байгуулагдаад богино хугацаа өнгөрсөн. Тэгэхдээ цаашидаа бид нар шаардлагатай ажлуудыг ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Очирбат гишүүн тодруулчих.

Г.Очирбат: Эхний асуултад гомдол гаргасан төрийн албан хаагч нар байгаа юу гэж асуусан. Яг тоо баримттай байгаа бол байгаа, байхгүй бол байхгүй гээд хариулаад өгөөрэй.

2-т гэх юм бол Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн хуулийн үйлчлэх хүрээ. Энэ хуулийн үйлчлэлд Төрийн албаны тухай хуульд заасан төрийн, улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалтнууд гээд заачихсан байгаа шүү. Тийм.

Тэгэхээр нийтээр нь хамаарна гэсэн утга санаа энэ дээр чинь байгаа.

3-д гэх юм бол тэр яагаад энэ төрийн албан хаагч нарыг бид нар барьж байгаа бодлого бол төрийн алба цомхон, чадварлаг л байх ёстой шүү дээ. Түүнээс төрийн албанд ажиллаж байгаа хүмүүсийг бид нар яг түрүүн энэ зарим дарга нарын хэлээд байгаагаар дэмжих ёстой. Энэ чинь Монгол Улсын төр байна. Төрийн хар хайрцаг бодлого байна. Тэрийг авч явж байгаа мэргэшсэн боловсон хүчнүүд байна. Тийм ээ. Одоо ихэнх бид нар залуу боловсон хүчнүүдээ дээр Цэдэвсүрэн даргаас мэдээлэл авч л

байсан. Залуучууд орж ирж байна. Тэгэхдээ ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Хэн хариулах вэ? Амартөгс дарга хариулах уу? 7 номер. Тэр тоо баримт байгаа бол тэрийг нь хэлж өгөх. Тийм. Бусад нь ер нь саналын шинжтэй зүйл байж байгаа Очирбат гишүүн хэллээ шүү.

Ц.Амартөгс: Тийм. Саналыг тусгаж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллая. Ялангуяа төрийн албанд шинээр орж байгаа албан хаагчдад ёс зүйн зөрчил болон энэ хууль тогтоомжийг илүү чиглүүлэх гэдэг юм уу агуулгыг нь сурталчлан сургалтыг илүү зохион байгуулснаар аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлнэ ээ гэж харж байгаа.

Тэгэхээр сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд Ёс зүйн хороо, бүх байгууллагууд чиглүүлэх сургалтынхаа агуулгыг ёс зүйн хууль тогтоомжтой уялдуулж хэрэгжүүлнэ ээ гэж заасан байгаа. Тэгэхээр үүгээр хэрэгжинэ.

Тоон мэдээллийн хувьд энэ гаргасан 423 бүртгэгдсэн гомдол мэдээлэл маань төрийн албан хаагчидтай холбоотой гэж бүртгэгдсэн болохоос биш хаагчийн гаргасан уу, иргэний гаргасан уу гэдгээр ангилж бүртгээгүй байгаа.

Б.Баярбаатар: Энхтуяа гишүүн асуултаа асууна.

Д.Энхтуяа: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ боловсруулж оруулж ирсэн асуудлуудтай холбоотой надад асуух асуулт алга. Та бүхэнд мэдээжийн хэрэг төрийн албаныхаа ёс зүй энэ ажиллах хэм хэмжээндээ энэ бүх боловсруулалтыг оруулж ирсэн байх гэж ингэж бодож байна.

Тэгээд сая энэ танилцуулга дээр Солонгоо даргын танилцуулга дээр ерөнхийдөө энэ төрийн албаны ёс зүй гэдэг бол харилцаа, хандлага болон төсвийн үр дүнгүй зарцуулалт дээр бид нар энэ дээр шаардлага тавьж байгаа. Тэгээд энэ дээр хариуцлага тооцуулах ёстой гэсэн ийм журам орж ирж байна л даа.

Тэгэхээр би олон жишээ хэлэлцүүгээр хамгийн сүүлийн жишээгээр ярья л даа. Энэ төсвийн хэлэлцэж байгаа дээр энэ ард түмний дунд хэлэлцүүлэг болоод байгаа энэ Соёлын сайдын ваучерын асуудал байна л даа. Тэгээд энэ ваучер нь одоо энэ мэдээж төсөвтэй холбоотой яг энэ нь яг энэ төсвийн үр дүнгийн зарцуулалт мөн үү, биш үү гэдгийг тогтоогоогүй байгаа. Энэ дээр надад хэлэх юм алга. Гэхдээ ард түмний зүгээс маш их эсэргүүцэлтэй тулж байгаа энэ нөхцөлд энэ сайд ингэж жиргээд сууж байх юм. Сэтгэл сэргэтэл балбууллаа гээд. Энэ бас харилцаа хандлага энд ёс зүйтэй энэ хандлага энэ хүний хариулт ёс зүйтэй хамрагдах уу? Би түрүүн хэлсэн шүү дээ. Энэ төсвийн үргүй зарцуулалт гэдэг дээр магадгүй энэ нь орохгүй байж болно, тийм ээ. Үүнийг шинжлээд мэдээж, Засгийн газраас оруулж ирсэн төсөв төлөвлөгөө байх. Яг энэ дээр энэ ард түмнээс тийм ээ, сошиалаар маш олон гомдол саналууд ирээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ саналуудыг яг санал гэж авч үзэх үү. Эсвэл ард түмэн тэр 11 11-д яг албан ёсоор бичгээр өгөөд, тэр гомдож байгаа улсууд нь бичгээр өгсөн нөхцөлд энэ Ёс зүйн хорооны асуудлаар ордог ийм асуудал юм уу. Энэ дээр надад нэг тайлбар өгөөч ээ. Бүгдээрээ л ингээд 2, 3 хоног л нүдэн балай, чихэн дүлий ингээд л яваад байгаа байхгүй юу. Тэгээд өнөөдөр бид нар энд төрийн албаны ёс зүй юу гэдэг юм, дарга нарын ёс зүй, Их Хурлын гишүүдийн ёс зүй, сайд нарын ёс зүй гээд ингээд нэг хий хоосон зүйл яриад байгаа юм шиг л надад санагдаад байх юм.

Тэгэхээр үүнийг албан ёсоор бичих ёстой юм уу гэсэн энэ нэг асуулт байна.

2-т нь, сая Боловсролын яамнаас өгсөн энэ юунд журам дээр өсвөр насны хүүхдүүдэд ёс зүйн, ёс суртахууны хичээл заалаа. Нэлээн олон компани т үйл ажиллагаа явууллаа гээд ингээд тэгж байна. Тэгэхээр үүнийг зүгээр миний энэ хувийн санал шүү. Та бүхэн энэ боловсролын салбарт маш олон жил ажилласан учраас энэ дээр үр дүнгийн судалгаа байдаг байх. Миний бодлоор өсвөр насны хүүхдэд ёс зүй заагаад тэр олон санхүү, олон юмаа цаг заваа үрээд, хичээлийн хажуугаар энэ үр дүнгүй ажил юм биш үү. Ер нь өсвөр насны хүүхдийн ёс зүй гэдэг чинь гэрийн хүмүүжил, эцэг эхийн хүмүүжил байдаг л гэж би ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ ойлголт бол ойлголтын зөрүү байна уу? Тэгэхээр энэ өсвөр насны хүүхдүүдэд ёс зүйн хичээлийг ингэж олон цагаар зааж байхын оронд биеийн тамир, спортоор хичээллүүлж бие бялдар нь ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Солонгоо дарга хариулаад, дараа нь Батжаргал дарга. 4 номерын микрофоныг өгье.

Б.Солонгоо: Миний танилцуулга дээр гарсан энэ иргэдээс ирүүлж байгаа төрийн албаны хүнд суртал болон төрийн үйлчилгээг авахад тулгамдаж байгаа асуудалтай холбоотой гомдол, мэдээллийн танилцуулга бол Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11 11 төв дээр ирсэн гомдол, мэдээллийн тойм мэдээлэл байсан. 11 11 төвд иргэд утсаар болон бичгээр хандаж гомдол мэдээлэл өгөх боломжтой.

Тэгээд мэдээж ёс зүйн дэд хороодод бичгээр ирсэн гомдлыг авч байгаа байх. Тэгэхээр холбогдох хуульд заасны дагуу иргэдээс төрийн байгууллагад гаргах өргөдөл гомдлын энэ хуулиараа зохицуулж байгаа асуудлууд байгаа.

Б.Баярбаатар: Хариултаа авчхаад нэгмөсөн тодруулъя. 2 номер Батжаргал дарга.

Х.Батжаргал: Энхтуяа гишүүний асуултад нэмж хариулъя. Энэ бага ангийн, бага насны хүүхдүүдэд Ёс зүйн хичээл гэж яг тодорхой хичээлээр ингээж заах гэхээсээ илүүтэйгээр тантай санал нэг байгаа. Энэ гэхээсээ илүүтэйгээр нийгэмд зөв хүн болж хүмүүжих, илүү тэр үндэсний өв уламжлал, нэгдмэл үнэт зүйл, эх түүхийн агуулгыг тусгах энэ агуулгыг нь хөтөлбөрт тусгаад, шинэчлээд ингээд явж байгаа. Ялангуяа “Би Монгол хүн” гэдэг ийм тусгай хөтөлбөрийг шинэ хөтөлбөрт шинэчилж энэ найруулгад заагаад явж байгаа. Гэр бүлийн хүмүүжил бол 1 дүгээр ёс зүйн хамгийн чухал асуудал гэдэгтэй тантай санал нэг байгаа.

Б.Баярбаатар: Энхтуяа гишүүн тодруулна. Энхтуяа гишүүний микрофоныг өгье.

Д.Энхтуяа: Энэ харилцаа хандлага гэдэг дээр тэр Номин сайдын сэтгэл сэргэтэл балбууллаа гэдэг энэ гэж үзэгдэл, энэ гэж хариулт энэ ёс зүйн хандлагад орох уу? Энэ асуулт шүү.

2-т нь, энэ Ёс зүйн дэд хороо байгуулагдсан байгаа. Тэгээд энэ дээр би энэ Ёс зүйн дэд хороог дэмжсэн. 2025 оны төсөвт та бүхэнд нэлээн томоохон төсөв 13 тэрбум ч билүү тавигдсан. Энэ дээр дэмжээд ингээд явуулсан. Тэгээд түрүүн Бум-Очир гишүүний хэлснээр бид нар энэ нэг шинэ 30 жил гээд л тэгээд байна. Урд талын 30 жил энд нэг нийгмээс нөгөө нийгэм рүү шилжихэд ёс зүйн маш том алдаа гаргасан учраас дарга нар бид нар өөрсдөө ёс зүйгүй байгаа учраас энэ нийгмийг чинь ингээд хөдөлгөөд байна гэж би үзээд байгаа байхгүй юу. Хөдөлгөөд байна. Галзуучууд гэдэг юм уу, одоо энэ хүмүүс чинь сошиалд яг л галзуу л байна шүү дээ. Энэ чинь хүүхдүүд харж байгаа байхгүй юу.

Энэ чинь залуучууд үүгээр хүмүүжиж байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг энэ Ёс зүйн хороо байгуулагдаад нэг ийм өөрчлөлт реформ шинэчлэлт юм хийх юм уу, энэ ёс зүй дээрээ. Яаж энийгээ хэмжих юм ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Солонгоо дарга гүйцээгээд хариулчих.

Б.Солонгоо: Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Ёс зүйн энэ зөрчилтэй холбоотой ирүүлсэн гомдлыг Ёс зүйн хороо болон дэд хороод шийдвэрлэнэ.

Тэгэхээр ирээгүй байгаа гомдол дээр тодорхой байр суурийг у илэрхийлэх боломжгүй байна. Гэхдээ нэг зүйлийг тодруулахад Засгийн газрын тогтоолоор батлагдсан төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ гэдэг дээр тодорхой нэг заалт байгаа. Тэр нь юу вэ гэхээр ажлын байр, олон нийтийн газар, цахим орчин болон нийгмийн сүлжээнд төрийн албаны нэр хүндэд харшлах үйл ажиллагаанд оролцохгүй, үг үйлдэл гаргахгүй байх гэсэн хэм хэмжээг тодорхой тусгасан.

Тэгээд цаашидаа энэ Засгийн газрын тогтоолоор баталсан ёс зүйн хэм хэмжээг цаашид олон нийтэд сурталчлан таниулах дээр бидний зүгээс анхаарч ажиллах болно.

Б.Баярбаатар: Энхтуяа гишүүнд нэг минут өгчих.

Д.Энхтуяа: Тэгээд уучлаарай, энэ дандаа төрийн яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар том дарга нар ирсэн учраас би заавал хэн нэгний нэр төрд халдах гээд ингээд байгаа юм биш ээ. Хамгийн сүүлийн жишээ энэ ёс зүйн жишээ. Дарга нар өөрсдөө бид нар ямар байх вэ, сайдууд ямар байх вэ гэдэг үүднээс хандаад энэ жишээг хэлээд

байгаа шүү. Та бүхэн үүнийг авах гээхийн ухаанаар хандаарай гэж хэлье. Баярлалаа.

Б.Баярбаатар: Ер нь Энхтуяа гишүүний хэлж байгаа зөв шүү. Бид нар энэ эрхэлж байгаа албан тушаал, энэ улс төрийн албан тушаал, төрийн албан тушаал эрхэлж байгаа тохиолдолд хэдий хувийн орон зай, тэр цахим орчинд өөрийнхөө хувийн орон зайгаас мэдээлэл оруулж байгаа ч гэсэн тэр, нийгэм үүнийг чинь ингэж хардаггүй шүү.

Тэгээд ялангуяа өнөөдөр энэ ирэх жилийн төсөв хэлэлцэгдэж байгаа энэ цаг үе дээр маргаан дагуулж байгаа асуудал дээр аль болох бид нар ёс зүй, ёс суртахуунаа эрхэмлэж ажиллах нь зөв байх гэж харж байгаа шүү.

Рэгдэл гишүүн асуулт.

Д.Рэгдэл: Баярлалаа. Өнөөдрийн энэ ярьж байгаа асуудал үнэхээр их л чухал асуудал л даа. Тэгээд ёс зүй, ёс суртахуун, сахилга хариуцлага бүхэн маань ер нь нийлсээр байгаад эцсийн эцэст тогтвортой нийгмийн хамгийн суурь үзүүлэлт л болоод байх шиг байдаг юм.

Тэгээд манай Монгол Улсын Ёс зүйн хороо байгуулагдаад тэгээд ер нь энэ Байнгын хорооны тогтоол гараад ингээд үндсэндээ нэг тийм зарим нь 1 жил ч хүрэхгүй, зарим нь 1 жил болоод байгаа л ийм л хугацаа өнгөрсөн байна, шинэхэн асуудал. Тэгэхээр энэ шинэхэн асуудлыг зогсоолгүй урагш нь авч явахын тулд нэлээн хүч чармайлт л шаардагдана. Үүнийг чинь зогсооё, саатуулья гэсэн хүчин байхыг үгүйсгэхгүй.

Тийм учраас нэлээн л анхааралтай, эрчимтэй ажиллах шаардлага байгаа юм уу гэж бодож байгаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулгыг 2 хоногийн өмнө өгсөн. Үүнд их баярлаж байгаа. Ингэж хугацаатай өгөх бол их чухал юм. Тэгээд энэ танилцуулгыг нэг гүйлгээд харахад яамдын хувьд нэг их төстэй. Аймгуудын хувьд хоорондоо их төстэй. Тэгсэн мөртөө их олон ажил хийчихсэн байгаа юм. Үүнийг Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо ч юм уу, Хэрэг эрхлэх газрын Ёс зүйн дэд хороо нь ч юм уу 1 нэгтгэж дүгнээд, бид нар нэг энэ дайны амжилттай явж байна, ийм асуудал үүсээд байна гэж хэлж өгвөл бид нарт хэрэгтэй байгаа юм.

Тэгээд өнөөдөр тэр асуудал үүсээд байгаа асуудлаар ер нь юм мэдээлэл өгсөнгүй. Түүн дээр та бүхэн маань анхаарч ажиллаарай. Зүгээр энэтэй холбогдуулаад би нэг зүйл асуух гэсэн юм. Энэ Байнгын хорооны тогтоолын 1-д дүгээр заалтыг хэзээ хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа юм бол? Тийм ээ. 2023 оны хаврын чуулганд л оруулах ёстой л юм байсан юм шиг байна. Намрын чуулганаар шийдэх ёстой. Тэгэхээр энд нэг хугацаа хэлж өгөөч.

2 дугаарт, энэ Ёс зүйн дэд хороод их олон байгуулагдсан юм байна. Боловсролын яам нь хэмжээнд нэг 2150 хэд, Цэдэвсүрэн даргын мэдээллээр нэг 2000 гаруй, ингээд нийтдээ нэг 2200 гаруй дэд хороо байгаа юм байна гэж ойлгосон, 4200 гаруй. Хэрвээ би зөв ойлгосон бол. Энэ аудитаас оруулж хэлж байгаа мэдээллээр болохоор Монголд чинь нэг 6000 гаруй байгууллага байна л гээд байгаа юм. Төсвийн болоод төсвийн бус төсөвтэй холбоотой төрийн өмчийн. Тэгэхээр энэ үлдсэн байгууллагууд нь дэд хороогоо байгуулаагүй юм уу, Ёс зүйн дэд хороогоо. Эд нартаа ер нь ямар арга хэмжээ авч байгаа юм гэсэн нэг ийм асуулт байна.

3 дахь асуулт бол энэ төрийн албаны хүний нөөцтэй холбоотой юм. Ер нь төрийн албаны хүний нөөц гэж нэг

тийм юм байдаг юм байна гэж би мэдээллээс харлаа. Тэгээд энэ хүний нөөцөө ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Рэгдэл гишүүнд нэг минут өгье.

Д.Рэгдэл: Хүний нөөцөө яаж хэрэгжүүлдэг юм бол? Ингээд практик дээр хараад байхад чинь том дарга нар нэг ажлаас нөгөө ажилд очихдоо нэг арми дагуулаад л оччих юм. Дунд зэргийн дарга нар нэг түүнээс арай жижигхэн хороо ч юм уу салаа дагуулаад л тэнд оччихдог. Тэгээд тэр очсон газар энэ мерит зарчим ер нь хэрэгжих тухай ер нь л юм явахгүй л байгаа юм л даа. Тэгэхээр үүнийг өөрчлөх талаар энэ төрийн албаны хүний нөөцийн бодлогоор зохицуулах боломж ер нь байдаг юм болов уу, байдаггүй юм болов уу гэсэн нэг ийм 3 асуулт байна.

Б.Баярбаатар: Эхлээд хэн хариулах вэ? Солонгоо дарга, дараа нь Цэдэвсүрэн дарга хариулъя.

Б.Солонгоо: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Бидний хувьд Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо яг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. Тэгээд холбогдох байгууллагууд дээр үйл ажиллагаа явуулж байгаа дэд хороод маань мөн хуульд заасан яг чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. Мэдээж цаашидаа энэ дэд хороодын үйл ажиллагааг уялдуулах ажлыг хуульд заасан чиг үүргээрээ Ёс зүйн хороо илүү нэгтгэж ажиллах байх.

Тэгэхээр бидний хувьд Монгол Улсын Ёс зүйн хороотой энэ чиглэлээр цаашид хамтарч, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг хамтарч зохион байгуулах дээр анхаарч ажиллах болно.

Тогтоолоор өгөгдсөн үүргийн хувьд хамтарсан Засгийн газар байгуулагдаад бид нарын хувьд хууль тогтоомжуудыг шинэчилж

боловсруулах ажлыг холбогдох салбар болгон дээр зохион байгуулж байна. Тэгээд энэ чиглэл өгсөн хүрээнд холбогдох хуулиудын төслүүдийг боловсруулах ажлуудыг зохион байгуулаад ажиллаж байна.

Б.Баярбаатар: Цэдэвсүрэн дарга 5 номерын.

Л.Цэдэвсүрэн: Рэгдэл гишүүний 2 асуултад хариулъя. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар яг төрийн албаны Ёс зүйн дэд хороо байгуулагдах асуудал нь нэг өөр. Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороо тэгээд томилох эрх бүхий албан тушаалтан гэсэн 3 ийм субъект байгаа юм. Орон тоо нь бага, цөөхөн байгууллагууд дээр Ёс зүйн дэд хороо заавал байгуулагдахгүй. Түүний чиг үүргийг хэн хэрэгжүүлэх юм гэхээр томилох эрх бүхий албан тушаалтан гээд. Бид нарын хийсэн судалгаагаар нийт Монгол Улсын хэмжээнд 4239 дэд хороод байгуулагдах ёстой юм байгаа юм. Бүртгэлээр. Үүнээс одоогийн байдлаар түрүүний миний хэлсэн тоогоор одоогоор бүртгэгдээд явж байна.

Салбарын тоо бол бас нэг арай өөр. Өмнө нь нөгөө нэг боловсролын салбарт жишээ нь байгууллага болгон дээр зөвлөлтэй байдаг байсан. Үүнийгээ магадгүй манай байгууллагууд хөрвүүлээд Ёс зүйн дэд хороо болгочихсон байхыг үгүйсгэхгүй. Бид нар энэ дээр Боловсролын яамтайгаа тооны тулгалт болон асуудлаа ярьж гээд.

Төрийн албан хаагчийн хүний нөөц ... /минут дуусав/

Б.Баярбаатар: 5 номер гүйцээгээд хариулъя.

Л.Цэдэвсүрэн: Төрийн албан хаагчийн хүний нөөцийг яаж хэрэгжүүлээд байна вэ гээд. Ер нь төрийн албан хаагч төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллага руу

хоёрхон тохиолдолд л ажил, юу, гуравхан тохиолдолд ажиллах ёстой.

Нэг нь шилжиж ажиллаж болно. Хуульд заасан шаардлага хангачих юм бол тэр хүн төрийн ижил түвшний байгууллагаас нөгөө рүү шилжээд ажиллаж болно.

2 дахь тохиолдолд нь сэлгэн ажиллаж болно. Сэлгэн ажиллаж. Бас л хуулийн зүйл заалттай. Тэгэхдээ энэ 2 тохиолдолд хоёуланд нь өөрөө хүсвэл гэдэг зүйл байгаа.

3 дахь зүйл нь юу вэ гэхээр бүтцийн өөрчлөлтийн асуудал. Яг одоогийн байдлаар өнөөдөр үнэндээ төрийн байгууллагуудад бүтцийн өөрчлөлтийг маш ихээр хийж байна. Энэ нь таны хэлээд байгаа магадгүй хэн нэгэн удирдах албан тушаалтныг дагаж явж байгаа хандлага харагдаад байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ Төрийн албаны зөвлөл бол албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл өгөхөөс эхлүүлээд томилгоотой холбоотой, чөлөөлөлттэй холбоотой бүх зүйлүүд дээр хяналт тавиад тодорхой зөвлөгөө чиглэлүүдийг өгч байгаа.

Б.Баярбаатар: Рэгдэл гишүүн болчихсон уу тийм ээ. Ойлголоо.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Танилцуулгатай холбоотой үг хэлэх гишүүд байна уу? Ер нь дундуур нь хэлчих шиг болсон тийм ээ. Алга байна.

Ирц бүрдүүлнэ шүү. 2 гишүүнээ дууд.

1 дүгээрт, би та бүхэнд энэ дахин танилцуулчихъя.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хорооны бие даасан, хараат бус ажиллах

нөхцөлийг хангах, эрх зүйн орчныг сайжруулах, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга Х.Баасанжаргал Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүдэд А.Ариунзаяа Улсын Их Хурлын гишүүн, Д.Бум-Очир Улсын Их Хурлын гишүүн, Д.Рэгдэл Улсын Их Хурлын гишүүн, Б.Хэрлэн Улсын Их Хурлын гишүүн, Д.Энхтуяа Улсын Их Хурлын гишүүн, Ц.Амартөгс Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Б.Пүрэвдагва Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ш.Батсүх Ёс зүйн хорооны гишүүн, Монгол сэтгэл зүйчдийн нийгэмлэгийн тэргүүн, доктор, профессор, Монгол Улсын Гавьяат багш, А.Алтанзул Удирдлагын академийн ахлах багш, доктор, С.Бат-Орших МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, Д.Наранцэцэг Ёс зүйн дэгийн Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх, Н.Ганбаатар Ёс зүйн хорооны ажлын албаны дарга, Б.Мажигсүрэн Зөвлөгөө үйлчилгээний хэлтсийн зөвлөх, О.Мөнгөнчавхдас Ёс зүйн дэгийн байнгын хорооны ажлын албаны референт.

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг хангах, эрх зүйн орчныг сайжруулах саналыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны дотор боловсруулж, Байнгын хороонд танилцуулахыг ажлын хэсэг Х.Баасанжаргалд даалгасугай гэсэн ийм ажлын хэсэг байгуулагдсан байгаа.

Тэгээд энэ дээр саяын гишүүдийн яриад байгаа энэ эрх зүйн орчин дээр тусгагдсан гажуудал байж болно. Зөрчил байж болно. Сайжруулах зайлиггүй шаардлагатай зүйлүүд байж болно. Эдгээрийгээ нэгтгэсэн байдлаар энэ ажлын хэсэг дээр нэгтгэгдээд орж ирж танилцуулагдана.

Өнөөдөр би Байнгын хорооны тогтоолын төсөл та бүхэнд танилцуулна. Өнгөрсөн 10 дугаар тогтоол дээр нэг 2 зүйл орхигдсон байна гэж харж байгаа.

1 дүгээрт, нь энэ сургалт, судалгааны асуудал. Ялангуяа энэ сургалтын асуудлыг нэг тодорхой тусгах нь зөв болов уу гэж харж байна.

2 дугаарт, энэ соён гэгээрүүлэх чиглэлээр ерөөсөө энэ 10 дугаар тогтоол дээр тусаагүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ 2-ыг томъёолж оруулна. Жишээ нь соён гэгээрүүлэхийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, соён гэгээрлийн ажлыг идэвхжүүлэх гэдэг ийм ажил байгаа. Үүнийг энэ 10 дугаар тогтоолд байхгүй байгаа учраас энэ дараагийн тогтоолд тусгах санал байна.

Ингээд би тогтоолын төслийг уншиж танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.5, 22.3.6 болон 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар тухай тогтоолын хэрэгжилтийг Ёс зүй, дэгийн байнгын хорооны хуралдаанаар сонссонтой холбогдуулан дараах арга хэмжээ авч эрчимжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай.

1.Байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 01 дүгээр зүйлийн 1.1, 1.3, 1.6, 1.7, 1.8, 1.9 дэх хэсгийг хэрэгжилтийг эрчимжүүлж, нийгмийн ёс суртахууны

түвшин, чиг хандлагыг тодорхойлох, суурь судалгаа хийж, Монгол хүний ёс суртахууны өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлагыг тодорхойлж, бүсийн хөгжлийн бодлогод тусгах,

2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлэх,

3. Тогтоолын биелэлтийн явцыг Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хорооны танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Ёс зүйн хороо Ц.Амартөгс, Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо Б.Солонгоод даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ёс зүй, дэгийн байнгын хороо Б.Баярбаатар даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Энэ дээр миний саяын хэлсэн тэр сургалттай холбоотой нэг заалт нэмнэ шүү. Ажлын алба тэмдэглэж аваад.

Ингээд тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ганмаа гишүүн орж ирж байна уу? Бум-Очир гишүүн хүндэтгэн үзэх шалтгаан гараад протоколд тэмдэглүүлээд, тогтоолын төсөлтэй танилцлаа. Дэмжиж санал өгье гэсэн учраас протоколд тэмдэглүүлье.

Санал хураалтад бэлтгэе.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж, асуулт, санал дууссан учраас.

Гишүүд сая нэлээн чухал чухал асуултуудыг асуусан. Манай Ёс зүйн дэд хороод удирдаж байгаа дарга нар энэ дээр их анхааралтай хүлээж авч ажиллаарай. ЗГХЭГ сая шинэ Засгийн газар байгуулагдсанаас хойш Ёс зүйн дэд хороо байгуулагдаад удаагүй байгаа. Үүнийг та бүхэн нэг ойлгож учирлаарай. Ерөөсөө анх удаа байгуулагдаж байгаа. Өмнө нь байгаагүй. Тэгээд Солонгоо дарга ажил аваад удаагүй. Дээр нь Ёс зүйн дэд хороон даргаар томилогдоод бүр бүр удаагүй байгаа. Тэгэхээр нөгөө шинэхэн будаг нь ханхалсан гэдэг шиг ажлын туршилагын хувьд би Солонгоо дэд даргад, харин их олзуурхууштай зөв хүнээ энэ Ёс зүйн дэд даргаар тавьж гэж би их олзуурхаж байгаа. Цаашидаа энэ ажлыг маш богино хугацаанд эрчимжүүлээд, Ёс зүйн хороотойгоо хамтраад ингээд ажиллах ийм боломжийг бүрдүүлээд явчихад итгэл дүүрэн байгаа учраас манай гишүүд энэ дээр их дэмжиж ажиллаарай гэж би та бүхэндээ хүсмээр байна.

Нэг бүртгэлийн санал хураалт явуулна. Бүртгэлийн санал хураалтыг явуулъя.

Манай Байнгын хороо бусад Байнгын хороодоо бодвол хамгийн цөөхөн гишүүнтэй. Тэгэхдээ ач холбогдлын хувьд хамгийн том агуулгатай Байнгын хороо шүү. Тэгээд манай Төрийн албаны зөвлөл, Монгол Улсын Ёс зүйн хороо сүүлийн үед маш их манлайлал үзүүлж ажиллаж байгаад талархал илэрхийлье. Байнгын хорооныхоо зүгээс. Цаашидаа бид нар идэвхжүүлэх ёстой. Би үүнийг яагаад хэлж байна гэхээр тэр Төрийн нарийн бичгийн дарга нарыг сонсож аваарай гэж хэлж байгаа юм. Цаашидаа танай салбаруудын чиглэлийн байгууллагууд үүнийг эрхэмлэж явах ёстой учраас

ажил болгож хэрэгжүүлэх ёстой учраас би үүнийг хэлж байгаа юм шүү.

Санал хураалт явагдана. Сая би тогтоолын төсөл уншаад танилцуулсан.

Төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт, санал гаргаагүй учраас тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 75 хувь дэмжиж, тогтоол батлагдлаа.

Дээр нь Бум-Очир, Энхтуяа гишүүн 2 протоколд “дэмжсэнээр” оруулж байгаа учраас 100 хувиар тогтоол батлагдлаа.

Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг нийт төрийн албан хаагчдадаа бүгдэд нь дахин үүрэг болгоё.

16.57 цаг

Баярлалаа.

Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудал дууслаа.

Хуралдаанд хүрэлцэн ирсэнд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ